



*Албан бус орчуулга*

ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ  
ТӨЛӨВЛӨГӨӨ

МОНГОЛ УЛСЫН ТЭЭВРИЙН ХОЛБОЛТ БОЛОН  
ЛОГИСТИКИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ (P174806),  
БОЛОН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

2026 оны 02 сарын 23

Эцсийн хувилбар

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ .....	3
1. ТАНИЛЦУУЛГА .....	4
2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	4
3. ОТХТ-НИЙ ЗОРИЛГО БА ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	6
3.1 Оролцогч талуудыг тодорхойлох, шинжилгээ хийх .....	7
3.2 Арга зүй .....	7
3.3 Нөлөөлөлд өртсөн талууд .....	8
3.4 Бусад сонирхогч талууд.....	9
3.5 Ядуу/эмзэг бүлэг, хувь хүмүүс.....	9
4. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	10
4.1 Төслийн бэлтгэл үе шатанд хийсэн оролцогч талуудын оролцооны тойм.....	10
4.2 Төслийн оролцогч талуудын хэрэгцээ, оролцогч талуудтай харилцах арга, хэрэгсэл, техникүүдийн хураангуй .....	11
4.3 Оролцогч талуудтай харилцах төлөвлөгөө.....	13
4.4 Оролцогч талуудад эргэн мэдээлэх .....	16
4.5 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл түгээх .....	17
5. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨӨЦ БА ХАРИУЦЛАГА .....	18
5.1 Нөөц.....	18
5.2 Удирдлагын чиг үүрэг ба хариуцлага .....	20
5.3 Баримтжуулалт ба бүртгэл хөтлөлт .....	20
5.4. Оролцогч талуудтай харилцах төлөвлөгөөний заавал мөрдөх доод шаардлага ба хэрэгжилтийн зохицуулалт .....	20
5.4.1 Ажил эхлүүлэхийн өмнөх нөхцөлүүд .....	21
5.4.2 Олон нийтийн оролцооны хамгийн бага шаардлага .....	21
5.4.3 Карьер болон түр газар ашиглалтын талаарх зөвлөлдөх үйл ажиллагаа .....	22
5.4.4 Санал, гомдол шийдвэрлэх гүйцэтгэлийн үзүүлэлт.....	22
5.4.5 БХМ/БД-ын эрсдэлийг бууруулах шаардлага .....	22
5.4.6 Тайлагнал ба баримтжуулалтын шаардлага .....	23
5.4.7 Үл нийцэл ба залруулах арга хэмжээ .....	23
6. ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ .....	23

6.1. ГБМ-ын тайлбар.....	24
7. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ТАЙЛАГНАЛ.....	25
7.1 ОТХТ-ний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, тайлагналын тойм.....	25
7.2 Оролцогч талуудад хариу мэдээлэх .....	28
ХАВСРАЛТ 1: ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТОДОРХОЙЛОЛТ, ШИНЖИЛГЭЭ .....	29
ХАВСРАЛТ 2: ӨМНӨ ХИЙГДСЭН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА .....	31
ХАВСРАЛТ 3: ЗАГВАРУУД.....	33
Загвар 1. Зөвлөлдөх уулзалтын тэмдэглэл .....	33
Загвар 2. Мэдээлэл түгээх, оролцогч талуудын оролцооны бүртгэл .....	33
Загвар 3. Олон нийтийн оролцооны бүртгэл .....	34
Загвар 4. Сар бүрийн оролцогч талуудын оролцооны бүртгэл .....	34
Загвар 5. ТТАМ-ын талбайн зөвлөлдөх бүртгэлийн маягт .....	35
Загвар 6. Эмзэг бүлгийн бүлгийн ярилцлагын бүртгэл .....	36
Загвар 7. Гүйцэтгэгчийн ОТХТ-ний хэрэгжилтийн тайлагналын товч агуулга .....	37
Загвар 8. БХМ/БД асуудлаар мэдлэг олгох сургалтын бүртгэл.....	38

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БОНС	Байгаль орчин, нийгмийн стандарт
БОНМХ	Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ
БОНМТ	Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
БОНХ	Байгаль орчин, нийгмийн хүрээ
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БХМ/БД	Бэлгийн хүчирхийлэл мөлжлөг/ бэлгийн дарамт
ГБМ	Гомдол барагдуулах механизм
ГШҮ	Гомдол шийдвэрлэх үйлчилгээ
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТЯ	Зам, тээврийн яам
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэр
МУТХБЛСТ	Монгол Улсын тээврийн холболт ба логикийг сайжруулах төсөл
НТХН	Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж
НШБХ	Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ
НШТ	Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө
ОУСБХБ	Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк
ОУХА	Олон улсын хөгжлийн ассоциаци
ОТХТ	Оролцогч талуудтай харилцах төлөвлөгөө
СЯ	Сангийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ТТАМ	Түгээмэл тархацтай ашигт малтмал
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХМЖ	Хөдөлмөрийн менежментийн журам
ШТС	Шатахуун түгээх станц

## 1. ТАНИЛЦУУЛГА

Энэхүү баримт бичиг нь Монгол Улсын Тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл (МУТХБЛСТ, Р174806) болон түүний нэмэлт санхүүжилтийн хүрээнд хэрэгжих Оролцогч талуудтай харилцах төлөвлөгөө (ОТХТ)-г юм.

Төслийн ОТХТ нь анх 2021 оны 7 дугаар сард боловсруулагдсан бөгөөд 2023 оны 6 дугаар сар, 2025 оны 11 дүгээр сарын 27, мөн 2026 оны 2 дугаар сарын 23-нд сард тус тус шинэчлэгдсэн. Энэхүү шинэчилсэн төлөвлөгөө нь нэмэлт санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг оролцуулан төслийн бүх бүрэлдэхүүн хэсэгт хамаарна.

ОТХТ нь олон нийтэд нээлттэй баримт бичиг бөгөөд төсөл хэрэгжих хугацааны турш Зам, тээврийн яам (ЗТЯ)-ны цахим хуудсаар дамжуулан чөлөөтэй танилцах боломжтой байна.

Төслийг Дэлхийн Банкны Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк (ОУСБХБ)-ны зээл болон Олон улсын хөгжлийн ассоциаци (ОУХА)-ын хөнгөлөлттэй зээлээс бүрдэх хосолсон санхүүжилтийн багцаар дамжуулан хэрэгжүүлж байна. Зээлдэгч нь Монгол Улсын Засгийн газар бөгөөд Сангийн яамаар төлөөлүүлнэ. Төслийг хэрэгжүүлэгч байгууллага нь ЗТЯ юм.

Төслийн байгаль орчин, нийгмийн холбогдох баримт бичгүүд нь Дэлхийн Банкны Байгаль орчин, нийгмийн хүрээ (БОНХ)-ний шаардлагад нийцүүлэн, 2018 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандартын дагуу боловсруулагдан хэрэгжиж байна. Үүнд дараах баримт бичгүүд багтана.

- Бүх бүрэлдэхүүн хэсгийг хамарсан Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ
- Оролцогч талуудтай харилцах төлөвлөгөө
- Тодорхой авто замын засвар, арчлалтын багцуудад зориулсан Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
- Хөдөлмөрийн менежментийн журам, ажилчдын гомдол барагдуулах механизмын хамт
- Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ
- Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө (шаардлагатай тохиолдолд газар чөлөөлөлт эсвэл ашиглалтын хязгаарлалт үүсэх үед хэрэгжүүлэх)

ОТХТ нь дээрх баримт бичгүүдийн салшгүй хэсэг бөгөөд Байгаль орчин, нийгмийн стандарт 10 (БОНС10)-ын дагуу оролцогч талуудтай харилцах, мэдээллийн ил тод байдлыг хангах үндсэн хэрэгсэл болно.

## 2. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн зорилго нь Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий нийлүүлэлтийн сүлжээ, логистикийн гол чиглэлүүдийн тээврийн холболтыг сайжруулах, логистикийн үр ашгийг нэмэгдүүлэх, мөн ЗТЯ-ны институцийн чадавхыг бэхжүүлж, авто замын дэд бүтцийг төлөвлөх, хэрэгжүүлэх, ашиглалт ба арчлалтыг үр дүнтэй гүйцэтгэхэд оршино. МУТХБЛСТ нь дараах дөрвөн бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Бүрэлдэхүүн хэсэг 1. Дэд бүтцийн хөрөнгө оруулалт: Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь Монгол Улсын улсын авто замын сүлжээний ойролцоогоор 2,700 км стратегийн ач холбогдол бүхий замын хэсгүүдийн шинэчлэл, сэргээн засварлалт, болон урсгал засварын ажлыг дэмжинэ. Тэргүүлэх хөрөнгө оруулалтад А0301, А0302, А0501 зэрэг гол тээврийн коридорын замууд болон малчдын өрх, орон нутгийн үйлдвэрлэгчдийг зах зээлтэй холбох зорилготой ойролцоогоор 51 км орон нутгийн “сүүлийн миль” холболтын замууд багтана. Мөн энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь авто замын хөрөнгийн удирдлагын тогтолцоог бэхжүүлнэ.
- Бүрэлдэхүүн хэсэг 2. Тээвэр, логистикийн үйлчилгээ: Энэ бүрэлдэхүүн хэсэг нь логистикийн төвүүдийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, нийлүүлэлтийн сүлжээ ба логистикийн платформ хөгжүүлэх, нийлүүлэлтийн сүлжээнд шинэлэг шийдлүүд (ялангуяа хөдөө аж ахуйн стратегийн нийлүүлэлтийн сүлжээ) турших, мөн гэрээт логистикийн үйлчилгээний зохицуулалт, стандартуудыг сайжруулах ажлыг дэмжинэ.
- Бүрэлдэхүүн хэсэг 3. Техникийн туслалцаа ба чадавх бэхжүүлэх: Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь төслийн удирдлагын дэмжлэг, техникийн зураг төсөл боловсруулах, институцийн чадавхыг бэхжүүлэх, экспортын логистикийг сайжруулах (махны нийлүүлэлтийн сүлжээг оролцуулан), уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар, мөн авто замын хөрөнгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр стратегийн судалгаа хийх зардлыг санхүүжүүлнэ.
- Бүрэлдэхүүн хэсэг 4. Онцгой байдлын нөхцөлд хариу арга хэмжээ авах бүрэлдэхүүн: Энэхүү бүрэлдэхүүн хэсэг нь онцгой нөхцөл байдал, гамшиг, эсвэл хямралын үед шаардлагатай санхүүжилтийг шуурхай дахин хуваарилж, яаралтай хариу арга хэмжээ болон сэргээн босголтын үйл ажиллагааг дэмжих боломжийг бүрдүүлнэ.

Төсөл нь хэд хэдэн аймаг, сумын нутаг дэвсгэрийг хамарч, малчид, орон нутгийн иргэд, тээвэр, логистикийн операторууд, орон нутгийн захиргаа, хувийн хэвшлийн логистикийн үйлчилгээ үзүүлэгчид болон төрийн байгууллагууд зэрэг өргөн хүрээний оролцогч талуудыг хамарна. Газарзүйн хамрах хүрээ өргөн, түр хугацааны барилгын нөлөөлөл, салбар хоорондын уялдаа шаардлагатай тул оролцогч талуудын үр дүнтэй оролцоог хангах нь төслийн амжилтын чухал нөхцөл юм.

### 3. ОТХТ-НИЙ ЗОРИЛГО БА ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ОТХТ нь төслийн бүхий л үе шатанд оролцогч талуудыг тодорхойлох, мэдээлэх, зөвлөлдөх болон оролцоог хангах үйл ажиллагааг системтэй, хүртээмжтэй, ил тод байдлаар хэрэгжүүлэх хүрээг тогтооно. ОТХТ нь Дэлхийн Банкны БОНС10: Оролцогч талуудтай харилцах ба мэдээллийн ил тод байдалд нийцүүлэн боловсруулагдсан бөгөөд Зээлдэгч болон төслийн оролцогч талуудын хоорондын нээлттэй, ил тод харилцаа нь олон улсын сайн туршлагын чухал бүрэлдэхүүн хэсэг болохыг хүлээн зөвшөөрдөг.

Энэхүү төлөвлөгөө нь төслийн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн цар хүрээ, шинж чанарт нийцүүлэн пропорциональ байдлаар хэрэгжих бөгөөд нэмэлт санхүүжилтийн хүрээнд хэрэгжих бүх бүрэлдэхүүн хэсгийг хамарна.

БОНС10 стандартын дагуу МУТХБЛСТ-ийн хүрээнд оролцогч талуудтай харилцах үндсэн зорилтууд нь дараах байдалтай байна:

1. Оролцогч талуудтай харилцах системтэй арга барилыг бүрдүүлэх: Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй болон бусад сонирхогч талуудыг тодорхойлж, тэдэнтэй урт хугацааны, бүтээлч харилцаа тогтоох, хадгалах.
2. Оролцогч талуудын сонирхол, хандлагыг үнэлэх: Талуудын төсөлд хандах байр суурь, санаа зовнил, хүлээлтийг ойлгож, төслийн зураг төсөл, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн менежмент болон хэрэгжилтийн шийдвэрт тэдний санал бодлыг тусгах.
3. Олон талт, үр дүнтэй оролцоог хангах: Төслийн нөлөөлөлд өртөж буй иргэд, ялангуяа эмзэг болон нийгмийн хувьд сул дорой бүлгүүдийг төслийн бүх үе шатанд үр дүнтэй оролцуулах.
4. Мэдээллийг цаг тухайд нь, хүртээмжтэй байдлаар хүргэх: Байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөлөл, бууруулах арга хэмжээ, барилгын ажлын хуваарь болон болзошгүй саад бэрхшээлийн талаар ойлгомжтой, соёлын онцлогт нийцсэн, хүртээмжтэй хэлбэрээр мэдээлэл түгээх.
5. Гомдол барагдуулах хүртээмжтэй механизм бүрдүүлэх: Төслийн нөлөөлөлд өртөж буй талуудад асуудал, гомдлоо илэрхийлэх боломж олгож, төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудад тэдгээрийг цаг тухайд нь, үр дүнтэй шийдвэрлэх ил тод, хүртээмжтэй гомдол барагдуулах тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх.

БОНС10-ийн шаардлагаас гадна энэхүү ОТХТ нь Монгол Улсын холбогдох хууль, эрх зүйн зохицуулалтыг тусгасан болно. Үүнд:

- Хот байгуулалтын тухай хууль (2015): Иргэдийн оролцоог хангах, тэдний амьдралд нөлөөлөх шийдвэрийг цаг тухайд нь ил тод мэдээлэх шаардлага.
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012): Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний баримт бичгийг олон нийтэд нээлттэй болгох, багадаа 30

ажлын өдрийн хугацаанд санал авах, орон нутгийн захиргаа болон иргэдтэй зөвлөлдөхийг шаарддаг.

- Инженерийн шугам сүлжээний үйлчилгээний тасалдал болон дэд бүтцийн барилга, засварын ажлын талаар урьдчилан мэдэгдэх үндэсний хууль тогтоомжийн шаардлагууд.

Ийнхүү ОТХТ нь олон улсын БОНХ болон үндэсний эрх зүйн шаардлагуудыг нэгтгэсэн, нэгдмэл, цогц оролцогч талуудтай харилцах тогтолцоог бүрдүүлнэ.

### **3.1 Оролцогч талуудыг тодорхойлох, шинжилгээ хийх**

МУТХБЛСТ-ийг ил тод, хүртээмжтэй байдлаар хэрэгжүүлэх, мөн үндэсний хууль тогтоомж болон Дэлхийн банкны БОНХ-ний шаардлагад нийцүүлэхэд оролцогч талуудыг зөв тодорхойлж, шинжлэх нь чухал ач холбогдолтой юм. Төсөл нь олон бүрэлдэхүүн хэсэгтэй, газарзүйн хувьд хэд хэдэн аймаг сумын нутаг дэвсгэрийг хамран хэрэгжих ба дэд бүтцийн хөрөнгө оруулалт болон логистикийн салбарын шинэчлэлийг багтааж байгаа тул оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааг системтэй, төслийн нөлөөлөлд тохирсон арга барилаар хэрэгжүүлэх шаардлагатай. Оролцогч талуудыг тодорхойлох болон шинжлэх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 1-д тусгасан болно.

Төслийн оролцогч тал хувь хүн, бүлгүүдийг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

1. Төслийн нөлөөлөлд өртөж байгаа эсвэл өртөх магадлалтай (төслийн нөлөөлөлд өртсөн талууд); болон/эсвэл
2. Төслийн үйл ажиллагаа, үр дүнтэй холбоотой ашиг сонирхолтой байж болох (бусад сонирхогч талууд).

### **3.2 Арга зүй**

Төсөл нь оролцогч талуудын оролцоог хангах зорилгоор дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

- Нээлттэй байдал ба төслийн бүх үе шатыг хамарсан хандлага: Төслийн олон нийтийн зөвлөлдөх үйл ажиллагааг төслийн хэрэгжилтийн бүх үе шатанд зохион байгуулах ба аливаа гадны нөлөөлөл, хөндлөнгийн оролцоо, албадлага, айлган сүрдүүлэлтээс ангид, нээлттэй байдлаар хэрэгжинэ.
- Мэдээлэлтэй оролцоо ба санал хүсэлт: Бүх оролцогч талуудад мэдээллийг тохиромжтой хэлбэрээр хүргэж, өргөн хүрээнд түгээнэ. Оролцогч талууд санал хүсэлтээ илэрхийлэх боломжийг бүрдүүлж, ирүүлсэн санал, шүүмжлэл, санаа зовоосон асуудлыг шинжлэн судалж, шийдвэрлэх нөхцөлийг хангана.
- Хүртээмжтэй байдал ба мэдрэмжтэй хандлага: Оролцогч талуудыг тодорхойлох үйл явцыг харилцаа холбоог сайжруулах, үр дүнтэй харилцааг бий болгоход чиглүүлнэ. Төслийн оролцооны үйл явц нь хүртээмжтэй байна. Бүх оролцогч талуудыг зөвлөлдөх явцад оролцохыг дэмжинэ. Мэдээлэлд тэгш хүртээмжтэй байх нөхцөлийг

бүрдүүлнэ. Оролцооны арга хэлбэрийг сонгохдоо оролцогч талуудын хэрэгцээнд мэдрэмжтэй хандах үндсэн зарчмыг баримтална. Ялангуяа эмзэг бүлгийн иргэдэд онцгой анхаарал хандуулна. Үүнд эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, шилжин суурьшсан иргэд, шилжин ирсэн ажилчид болон өөр өөр угсаатны бүлгүүдийн соёлын онцлог багтана.

- Уян хатан байдал: Нийгмийн зай барих шаардлага, соёлын нөхцөл байдал (жишээлбэл, жендэрийн онцгой харилцаа), эсвэл засаглалын хүчин зүйлс (жишээлбэл, хариу арга хэмжээ авах эрсдэл өндөр байх) нь уламжлалт нүүр тулсан оролцоог хязгаарлаж байгаа тохиолдолд оролцооны арга зүйг өөрчилж, интернет болон утасны харилцаанд суурилсан зэрэг өөр хэлбэрийн харилцаа холбоог ашиглана.

### **3.3 Нөлөөлөлд өртсөн талууд**

Нөлөөлөлд өртсөн талууд нь Төслийн үйл ажиллагаанаас шууд эерэг эсвэл сөрөг нөлөөлөлд өртөх магадлалтай хувь хүн, бүлгүүдийг хамарна. МУТХБЛСТ-ийн онцлог, ялангуяа авто замын засвар шинэчлэл болон логистикийн дэд бүтцийн шинж чанарыг харгалзан үзвэл нөлөөлөлд өртсөн талууд дараах байж болно. Үүнд:

1. Авто замын дагуух орон нутгийн иргэд: (жишээлбэл, авто замын трассын дагуу байрлах бэлчээрийг ашигладаг малчид болон мал бүхий өрхүүд; засвар хийгдэж буй авто замын дагуу байрлах сум, багийн төвийн оршин суугчид; барилгын ажлын түр нөлөөлөлд өртөх боломжтой өрхүүд (тоосжилт, дуу чимээ, замын хөдөлгөөний түр зохицуулалт гэх мэт); зам дагуух жижиг бизнес эрхлэгчид (шатахуун түгээх станц, дэлгүүр, засвар үйлчилгээ гэх мэт)
2. Нөлөөлөлд өртсөн коридорыг ашигладаг тээврийн машины операторууд болон жолооч нар (жишээлбэл, тухайн чиглэлийг тогтмол ашиглагчид, орон нутгийн иргэд, бизнес эрхлэгчид гэх мэт; улирлын шинжтэй зам ашиглагчид; жуулчид зорчигчид, нэг удаагийн зорилгоор түр зорчигчид)
3. Малчдыг холбох орон нутгийн чанартай замын зорчигчид (жишээлбэл, сайжруулсан замаас үр шим хүртэх алслагдсан малчин өрхүүд; хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчид болон махны нийлүүлэлтийн сүлжээний оролцогчид)
4. Түр хугацааны газар ашиглагчид (жишээлбэл, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах талбай, хаягдал материалын талбайн ойролцоох бэлчээр ашиглагч иргэд)
5. Ажилчид (жишээлбэл, барилгын ажилчид, түүний дотор гэрээт ажилчид, кемпид байрлаж буй ажилчид, орон нутгаас түр ажилчид)

Болзошгүй эерэг нөлөөлөлд замын хөдөлгөөний аюулгүй байдал сайжрах, зорчих хугацаа багасах, тээврийн хэрэгслийн ашиглалтын зардал буурах, зах зээлийн хүртээмж нэмэглэх зэрэг болно.

Болзошгүй сөрөг нөлөөлөлд түр хугацааны замын хөдөлгөөний саатал, барилгын ажлын үеийн тоосжилт, дуу чимээ, малын хөдөлгөөн хязгаарлагдах, мөн түр хугацааны хүртээмжийн хязгаарлалт зэрэг багтаж болно.

### 3.4 Бусад сонирхогч талууд

Бусад сонирхогч талууд гэдэгт төслийн нөлөөлөлд шууд өртөхгүй байж болох боловч тухайн төслийг сонирхох эсвэл хэрэгжилтэд нь нөлөөлөх боломжтой хувь хүн, байгууллагуудыг хэлнэ. Үүнд:

1. Төрийн байгууллагууд
2. Иргэний нийгмийн болон төрийн бус байгууллагууд (ТББ)
3. Хувийн хэвшлийн байгууллагууд
4. Шинжлэх ухаан, судалгааны байгууллагууд
5. Хөгжлийн түншүүд

Эдгээр оролцогч талууд нь хяналт тавих, техникийн санал зөвлөмж өгөх, эсвэл өмгөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх замаар олон нийтийн ойлголт болон төслийн үр дүнд нөлөөлж болно.

### 3.5 Ядуу/эмзэг бүлэг, хувь хүмүүс

Төслийн нөлөөллийн бүсэд төслийн эрсдэл, сөрөг нөлөөлөлд бусдаас илүү өртөх, эсвэл мэдээлэл авах, оролцох боломжид хамрагдах, төслийн үр өгөөж хүртэхэд саад бэрхшээлтэй тулгарч болзошгүй тодорхой хувь хүн, бүлгүүд байж болно.

Хүснэгт 1. Болзошгүй эмзэг, ядуу бүлгүүд

Бүлэг	Болзошгүй саад бэрхшээл	Оролцоог хангах арга хэмжээ
Өрх толгойлсон эмэгтэйчүүд	Хөдөлгөөний хязгаарлалт, шийдвэр гаргах боломжийн хязгаарлалт	Тусгайлсан уулзалтууд, эмэгтэйчүүдийн бүлгээр дамжуулан зорилтот мэдээлэл түгээх
Ахмад настан	Хөдөлгөөний хүндрэл, цахим мэдээлэлд хандах боломж хязгаарлагдмал	Орон нутгийн түвшний уулзалтууд: багийн Зсаг даргаар дамжуулан дэмжлэг үзүүлэх
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	Орчны хүртээмжийн саад, мэдээлэл дамжуулах хэлбэртэй холбоотой хязгаарлалт	Хүртээмжтэй байршил, энгийн ойлгомжтой мэдээлэл
Бага орлоготой малчин өрхүүд	Тээврийн хэрэгслийн хүртээмж хязгаарлагдмал, алслагдсан байршил	Сум, багийн Засаг даргаар дамжуулан мэдээлэл хүргэх
Улирлын чанартай шилжин ажиллагчид	Орон нутгийн үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголт хомс	Ажлын байранд мэдээлэл түгээх, ажилчдын гомдол барагдуулах механизм ажиллуулах
Барилгын ажилчид	Эрх мэдлийн тэнцвэргүй байдал, өшөө авах вий гэсэн айдас	Нууцлалыг хангасан ажилчдын ГБМ, ажилчдын ёс зүйн дүрмийн талаарх мэдээлэл, ойлголт
Карьер орчмын газар ашиглагчид	Албан бус газар ашиглалтын зохицуулалт	Талбай ашиглалтад орохоос өмнө шууд зөвлөлдөх

Монгол Улсад, төслийн хамрах хүрээнд Дэлхийн банкны БОНС 7-ын дагуу тодорхойлолтын дагуу Уугуул иргэд хамаарахгүй боловч уламжлалт мал аж ахуйн хэв маяг болон улирлын нүүдлийн онцлогтой холбоотой соёлын мэдрэмжийг харгалзан үзэх шаардлагатай.

Эмзэг бүлгүүдтэй үр дүнтэй харилцахад дараах төлөөллийн байгууллагууд дэмжлэг үзүүлж болно. Үүнд:

- Сумын Засаг даргын тамгын газар,
- Багийн Засаг дарга нар,
- Эмэгтэйчүүдийн холбоод,
- Малчдын хоршоо, нөхөрлөл
- Үйлдвэрчний эвлэлийн байгууллагууд (холбогдох тохиолдолд)

Эмзэг бүлгүүдийг төслийн хэрэгжилтийн явцад, ялангуяа дэд төслүүдийн барилгын ажлыг эхлүүлэхээс өмнө илүү нарийвчлан тодорхойлж баталгаажуулна. Тэгш, хүртээмжтэй оролцоог хангах зорилгоор шаардлагатай тохиолдолд тусгайлсан зөвлөлдөх уулзалт болон тухайн бүлэгт тохирсон оролцооны аргуудыг хэрэгжүүлнэ.

#### 4. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

МУТХБЛСТ-ийн хүрээнд оролцогч талуудын оролцоог төслийн бэлтгэл ажлын эхний үе шатнаас хангаж ирсэн бөгөөд төслийн хэрэгжилтийн туршид үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Оролцооны үйл ажиллагааг төслийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн цар хүрээ, эрсдэлийн түвшинд тохируулан хэрэгжүүлсэн бөгөөд үндэсний түвшний байгууллагын оролцогч талууд болон авто замын коридор, логистикийн хөгжлийн бүс нутгийн орон нутгийн иргэд, олон нийтийг хамруулсан.

##### 4.1 Төслийн бэлтгэл үе шатанд хийсэн оролцогч талуудын оролцооны тойм

Төслийн бэлтгэл үе шатанд зураг төсөл боловсруулах, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагын баримт бичгүүдийг боловсруулах зорилгоор үндэсний, аймаг болон сумын түвшинд олон нийтийн хэлэлцүүлэг, байгууллагуудын зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулсан. Хэлэлцүүлгүүдийг төслийн нөлөөлөлд өртөх аймаг, сумдуудад, тэргүүлэх авто замын чиглэлийн дагуу зохион байшуулсан бөгөөд үүнд дараах (үүгээр хязгаарлагдахгүй) байршлууд хамрагдсан.

##### Хүснэгт 2. Урьдчилсан зөвлөлдөх уулзалтын байршлууд болон оролцогчид

Төслийн аймгууд	Уулзалт зохион байгуулсан газар	Оролцогчид
<ul style="list-style-type: none"> <li>• Улаанбаатар</li> <li>• Төв аймаг (А0301 авто замын чиглэлийн дагуух Эрдэнэсант болон бусад сумд)</li> <li>• Булган аймаг</li> <li>• Архангай аймаг</li> <li>• Өвөрхангай аймаг</li> <li>• Хэнтий аймаг</li> <li>• Дорнод аймаг (зүүн чиглэлийн авто замын засварын ажилд )</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Аймгийн Засаг даргын тамгын газар</li> <li>• Сумын Засаг даргын тамгын газар</li> <li>• Иргэний танхимууд</li> <li>• Авто замын чиглэлийн дагуух төслийн талбайнууд</li> <li>• Улаанбаатар хот дахь яамдын албан өрөөнүүд</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Аймаг, сумдын Засаг дарга нар болон мэргэжилтнүүд</li> <li>• Байгаль орчин болон газрын асуудал хариуцсан орон нутгийн төлөөлөгчид</li> <li>• Малчид болон мал бүхий өрхүүд</li> <li>• Орон нутгийн иргэд болон жижиг бизнес эрхлэгчид</li> <li>• Зам ашиглагчид болон тээврийн үйлчилгээ эрхлэгчид</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Холбогдох салбарын яамдын төлөөлөл</li> <li>• Төсөл бэлтгэх зөвлөхүүд</li> </ul>
--	--	---

Төслийн бэлтгэл үе шатанд зохион байгуулсан бүр зөвлөлдөх уулзалтуудад сумдын түвшинд 10-15 оролцогчтой жижиг хэлэлцүүлэгээс эхлэн аймгийн түвшинд 30-50 оролцогчтой олон нийтийн өргөн хүрээний хэлэлцүүлэг хүртэл оролцооны цар хүрээ харилцан адилгүй байсан. Нийтдээ төслийн өөр өөр бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд хэдэн зуун оролцогч талуудтай зөвлөлдсөн. Зөвлөлдөх уулзалтуудын огноо, байршил, ирцийн бүртгэл, хэлэлцсэн асуудлууд болон ирүүлсэн санал хүсэлтийг хэрхэн тусгасан талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт 2-т оруулсан болно.

#### 4.2 Төслийн оролцогч талуудын хэрэгцээ, оролцогч талуудтай харилцах арга, хэрэгсэл, техникүүдийн хураангуй

Төслийн бэлтгэл үе шатанд зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтууд, авто замын трассын дагуух олон нийтийн уулзалтууд, байгууллага хоорондын уялдаа холбооны уулзалтууд болон ОТХТ-ний хүрээнд хийсэн оролцогч талуудын шинжилгээнд үндэслэн гол оролцогч талуудын хэрэгцээг тодорхойлсон. Оролцогч талууд нь төслийн үр дүн, үйл ажиллагаанд хандах сонирхол, нөлөөлөх боломж, төслийн нөлөөлөлд өртөх түвшний хувьд харилцан адилгүй байдаг. Тэдгээрийн хэрэгцээ нь төслийн үе шат (барилгын өмнөх үе, барилгын үе, ашиглалтын үе), газарзүйн байршил болон эмзэг байдлын түвшнээс хамааран ялгаатай байна.

Төсөлд өртсөн иргэд болон бусад сонирхогч талуудтай хийх зөвлөлдөх ажиллагааг төслийн бүх хугацаанд ЗТЯ-ны НТХН зохион байгуулна. НТХН-ийн Байгаль орчин, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд нь бүх зөвлөлдөх уулзалт, оролцооны үйл ажиллагааг хүртээмжтэй, оролцоог хангасан, соёлын онцлогт нийцсэн бөгөөд тухайн дэд төслийн цар хүрээ, эрсдэлийн түвшинтэй уялдсан байдлаар зохион байгуулалтыг хангаж ажиллана. Аймаг, сумын төрийн байгууллагуудтай хамтран ажилласнаар орон нутгийн түвшинд мэдээлэл түгээх, оролцоог хангах үйл ажиллагааны үр нөлөө нэмэгдэнэ.

#### Хүснэгт 3. Гол оролцогч талуудын хэрэгцээний хураангуй

Төрөл	Оролцогч тал	Гол хэрэгцээ / Сонирхож буй асуудал	Мэдээлэл хүргэх тохиромжтой арга	Онцгой анхаарах зүйлс
<b>А. Төсөлд өртөх талууд</b>				
Зам дагуух орон нутгийн иргэд	Малчид, мал бүхий өрхүүд	Барилгын ажлын талаар урьдчилан мэдээлэх; малын гарц, гармын зохицуулалт; ТТАМ-ын карьер ашиглах, нөхөн сэргээлт; тоосжилтыг бууруулах арга хэмжээ; ГБМ-д хандах боломж	Багийн Засаг даргаар дамжуулан мэдээлэх; биечлэн уулзалт; нийтийн зөвлөлдөх уулзалт; утас; жижиг бүлгийн уулзалт	Малчдын улирлын нүүдлийн хуваарийг харгалзах; өдрийн цагаар уулзалт зохион байгуулах

	Сум, багийн оршин суугчид	Барилгын ажлын хуваарь; замын хөдөлгөөний түр өөрчлөлт; дуу чимээ, тоосжилтын бууруулах арга хэмжээ; замын хөдөлгөөний аюулгүй байдлын сайжруулалт	Сумын мэдээллийн самбар; иргэдийн уулзалт; гар утасны мессеж; Facebook-ийн олон нийтийн бүлгүүд	Газар тариалангийн оргил үеийг зайлсхийх
	Барилгын ажлын түр нөлөөлөлд өртөх өрхүүд	Нөлөөллийн шинж чанар, үргэлжлэх хугацааны талаар тодорхой тайлбар; бууруулах арга хэмжээ; аюулгүй байдлыг хангах арга зам; санал хүсэлт, гомдол гаргах сувгууд	Биечлэн уулзах; утсаар холбоо барих; албан бичгээр мэдэгдэх; жижиг бүлгийн уулзалт; Facebook-ийн олон нийтийн бүлгүүд	Хувь хүнтэй ганцаарчилсан уулзалт хийхийг илүүд үзнэ
Зам дагуух бизнес эрхлэгчид	ШТС, дэлгүүр, засвар үйлчилгээний газрууд	Үйл ажиллагаанд саад учруулахгүй байх; хөдөлгөөний зохицуулалт; ажлын үргэлжлэх хугацаа	Уулзалт; албан бичиг; утасны дуудлага	Бизнесийн ажлын цагийг хүндэтгэх
Тээврийн үйлчилгээ эрхлэгчид болон жолооч нар	Замыг тогтмол ашиглагчид	Замын хөдөлгөөний түр чиглэл өөрчлөлт; аюулгүй байдлын тэмдэг тэмдэглэгээ; ажлын хугацаа	Вэбсайтын шинэчлэл; олон нийтэд зориулсан зар мэдээлэл; тээврийн холбоодоор дамжуулах; Facebook-ийн олон нийтийн бүлгүүд	Бодит цагийн мэдээллийг илүүд үздэг
	Улирлын болон түр хугацааны зам хэрэглэгчид	Зам хаах тухай мэдээлэл; онцгой арга хэмжээтэй холбоотой хөдөлгөөний өөрчлөлт	Олон нийтийн зар мэдээлэл; радио; социал медиа	Энгийн, ойлгомжтой мэдээлэл өгөх
Малчдыг холбох орон нутгийн зам ашиглагчид	Алслагдсан малчин өрхүүд	Зам ашиглалтад орох хугацаа; замын аюулгүй байдал; засвар арчлалтын үүрэг амлалт	Сумын түвшний уулзалт; багийн түвшний мэдээлэл түгээх ажил	Алслагдсан байршилд хүрэх хүндрэлтэй
	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчид болон махны өртгийн сүлжээний оролцогчид	Логистикийн сайжруулалт; тээврийн үр ашгийг нэмэгдүүлэх	Семинар; оролцогч талуудын уулзалт	Хөдөө аж ахуйн улирлын календартай уялдуулах
Түр газар ашиглагчид	Карьер орчмын бэлчээр ашиглагчид	Газрыг ашиглах хугацаа; нөхөн сэргээлтийн төлөвлөгөө; ГБМ-д хандах боломж	Шууд зөвлөлдөх уулзалт; албан мэдэгдэл; иргэдийн уулзалт; Facebook-ийн олон нийтийн бүлгүүд	Албан бус газар ашиглалтын зохицуулалтыг харгалзан үзэх
Ажилчид	Барилгын ажилчид (орон нутгийн болон гаднаас ирсэн)	Хөдөлмөрийн эрх; ХАБЭА; Ёс зүйн дүрэм; ажилчдын гомдол барагдуулах механизм	Танилцуулах сургалт; өдөр тутмын зааварчилгаа; самбар, постер; ажилчдын уулзалт; давтан сургалт	Нууцлалыг хангасан ажилчдын гомдол барагдуулах механизм
	Ажилчдын кемпэд байрлах ажилчид	Кемпийн нөхцөл; орон нутгийн иргэдтэй харилцах шаардлага	Талбайн уулзалт; постер; Ёс зүйн дүрмийн сургалт	Шаардлагатай тохиолдолд олон хэл дээрх материал ашиглах

<b>Б. Бусад сонирхогч талууд</b>				
Төрийн байгууллагууд	ЗТЯ	Төслийн хэрэгжилтийн явц; БОНС-ын хүрээний шаардлагын хэрэгжилт; гүйцэтгэлийн тайлагнал	Албан уулзалт; албан бичиг; тогтмол тайлагнал	Бүтэцлэгдсэн тайлагнал
	Авто замын бодлого зохицуулалтын газар	Замын хөрөнгийн удирдлагатай уялдуулах; техникийн зохицуулалт	Албан уулзалт; тайлан	Ажлын цагийн хүрээнд уулзалт зохион байгуулах
	Сангийн яам	Төсвийн хэрэгжилт; нийцлийн тайлагнал	Албан бичиг; албан тайлан	Албан ёсны баримт бичиг шаардлагатай
	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Өртгийн сүлжээний логистик; Малчдыг холбох орон нутгийн замын холболтын нөлөөлөл	Техникийн уулзалт	Улирлын төлөвлөлттэй уялдуулах
	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	БОНБУ-ний хуултын хэрэгжилт; хяналт шинжилгээний үр дүн	Албан бичиг; албан уулзалт	Зохицуулалтын хугацааг мөрдөх
	Аймаг, сумын Засаг даргын Тамгын газар	Барилгын ажлын хуваарь; гомдлын чиг хандлага; хамтын ажиллагаа	Албан бичиг; утас; Уулзалтын зохицуулалтыг хангах	Ажлын цагийн хүрээнд
Иргэний нийгмийн болон ТББ	Байгаль орчны чиглэлийн ТББ-ууд	Тоосжилтын хяналт; биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөлөл; карьерын нөхөн сэргээлт	Уулзалт; и-мэйл; олон нийтийн зөвлөлдөх уулзалт	Ил тод байдлын хүлээлт өндөр
	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлийн байгууллагууд	Аюулгүй байдлын сайжруулалт; ослоос урьдчилан сэргийлэх	Семинар; олон нийтийн уулзалт; Facebook-ийн олон нийтийн бүлгүүд	Баримт нотолгоонд суурилсан хэлэлцүүлэг
	Малчдын холбоод	Малын шилжилт хөдөлгөөний зохицуулалт	Шууд зөвлөлдөх уулзалт	Улирлын онцлогийг харгалзах
Хувийн хэвшил	Логистикийн компаниуд; ачаа тээврийн операторууд	Тээврийн үр ашгийг нэмэгдүүлэх; үйл ажиллагааны тасалдлыг бууруулах	Семинар; албан уулзалт; Facebook-ийн олон нийтийн бүлгүүд	Бизнесийн үйл ажиллагааны цагийн хуваарийг харгалзах
Судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагууд	Их сургуулиуд; судлаачид; иргэний шинжлэх ухааны оролцогчид	Мэдээлэлд нэвтрэх боломж; байгаль орчны мониторингийн үр дүн	Албан харилцаа холбоо; мэдээлэл солилцох	Шинжлэх ухааны стандарт мөрдөх
Хөгжлийн түншүүд	Дэлхийн банк болон бусад санхүүжүүлэгч байгууллагууд	БОНС-ын хүрээний шаардлагын хэрэгжилт; төслийн явцын тайлагнал; мониторингийн мэдээлэл	Албан тайлагнал; хяналт-шинжилгээний багийн томиллолт	Нийцлийн хугацааг мөрдөх

#### 4.3 Оролцогч талуудтай харилцах төлөвлөгөө

МУТХБЛСТ-ийн хүрээнд оролцогч талуудтай харилцах үйл ажиллагааг төслийн үе шат болон эрсдэлийн түвшинд үндэслэн зохион байгуулна. Оролцооны арга хэмжээ нь байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн түвшинтэй уялдсан байх бөгөөд бүх оролцогч талын хүртээмжтэй оролцоог хангаж, ялангуяа эмзэг болон давуу бус нөхцөлд байгаа бүлгүүдэд онцгой анхаарал хандуулна.

Хүснэгт 4. Оролцогч талуудтай харилцах төлөвлөгөө

Төслийн үе шат	Хугацаа	Зөвлөлдөх асуудал / Гол мэдээлэл	Ашиглах арга	Зорилтот оролцогч талууд	Хариуцах байгууллага
<b>Барилгын өмнөх үе шат</b>					
Төсөл бэлтгэх үе шат (дууссан)	2021–2023	Төслийн зураг төсөл; замын трасс; БОНС, БОНМТ, Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ; ГБМ-ын танилцуулга; хүлээгдэж буй үр өгөөж ба эрсдэлүүд	Олон нийтийн зөвлөлдөх уулзалт; байгууллага хоорондын уулзалт; ЗТЯ-ны вэбсайтаар мэдээлэл түгээх; аймаг, сумын түвшний уулзалтууд	Яамд; аймаг, сумын удирдлага; малчид; орон нутгийн иргэд; тээврийн жолооч нар	ЗТЯ; Төсөл бэлтгэх баг
Багц тус бүрийн ажил эхлүүлэх бэлтгэлийн өмнөх үе	Тухайн замын чиглэл тус бүрд ажил эхлэхээс 1–2 сарын өмнө	Барилгын ажлын хуваарь; Замын хөдөлгөөний зохицуулалтын төлөвлөгөө; малын гарц, гармын зохицуулалт; тоосжилт, дуу чимээ бууруулах арга хэмжээ; ТТАМ-ын карьер ашиглалт; ГБМ-ын журам; орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн боломж	Иргэдийн уулзалт; сумын ЗДТГ-т мэдээлэл байрлуулах; багийн Засаг даргад албан бичиг хүргүүлэх; бизнес эрхлэгчидтэй ганцаарчилсан уулзалт; фокус бүлгийн хэлэлцүүлэг	Замын дагуух иргэд; малчид; зам дагуух бизнесүүд; тээврийн жолооч нар; сумын удирдлага	НТХН; Гүйцэтгэгч; Хяналтын зөвлөх компани
<b>Эмзэг бүлгүүдэд чиглэсэн зорилтот мэдээлэл түгээх ажил</b>	Сум бүрт ажил эхлэхээс өмнө	Малын шилжилт хөдөлгөөний зохицуулалт; нэвтрэх боломжийн хязгаарлалт; өндөр настан, хүүхдэд учирч болзошгүй аюулгүй байдлын эрсдэл; ГБМ-д хүртээмжтэй хандах боломж	Тусгай фокус бүлгийн хэлэлцүүлэг; жижиг бүлгийн уулзалт; багийн Засаг даргаар дамжуулан өрхөөр очиж ажиллах; шууд зөвлөлдөх уулзалт	Өрх толгойлсон эмэгтэйчүүд; өндөр настан; хөгжлийн бэрхшээлтэй иргэд; орлого багатай алслагдсан малчин өрхүүд	НТХН-ийн Нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн; Гүйцэтгэгчийн нийгмийн ажилтан
<b>Барилгын үе шат</b>					

Барилгын ажлын эхний үе	Ажил эхэлснээс хойших эхний 3 сар	Барилгын ажлын нөлөөлөл (тоосжилт, дуу чимээ, чичиргээ); Замын хөдөлгөөний түр өөрчлөлт; ажилчдын ёс зүй; ГБМ-д хандах боломж; замын хөдөлгөөний аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээ; ТТАМ-ын карьер ашиглалтыг эхлүүлэхээс өмнөх зөвлөлдөх уулзалт; албан бус газар ашиглалтыг баримтжуулах	Олон нийтийн уулзалт; танилцуулга хуудас; талбайн мэдээллийн самбар; орон нутгийн радио; гар утасны мессеж мэдэгдэл	Нөлөөлөлд өртөх иргэд; жижиг бизнесүүд; зам хэрэглэгчид; малчид	Гүйцэтгэгч; НТХН
Үргэлжилж буй барилгын ажил	Улирал тутам	Ажлын явцын мэдээлэл; нөлөөлөл бууруулах арга хэмжээний хэрэгжилт; малын гарцын үр нөлөө; ТТАМ-ын карьерын нөхөн сэргээлтийн явц; ослын мэдээлэл; төлөвлөж буй дараагийн ажлууд	Иргэдийн уулзалт; хамтарсан талбайн үзлэг; сумын удирдлагатай албан уулзалт; олон нийтэд зориулсан мэдэгдэл	Иргэд; малчид; сумын удирдлага; байгаль орчны ажилтнууд; тээврийн жолооч нар	Гүйцэтгэгч; Зөвлөх инженер; НТХН
<b>Эмзэг бүлгүүдийн нөлөөллийн мониторинг</b>	Хагас жил тутам эсвэл шаардлагатай үед	Бэлчээрт хүрэх боломжийн мониторинг; өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих хөдөлгөөнд үзүүлэх нөлөө; гомдлын мөрөөр авах арга хэмжээ; замын хөдөлгөөний аюулгүй байдлын асуудлууд	Гэрээр очиж уулзах; тусгай фокус бүлгийн хэлэлцүүлэг; шаардлагатай тохиолдолд нууцлалыг хангасан ганцаарчилсан уулзалт	Эмзэг нөхцөлтэй эмэгтэйчүүд; өндөр настан; хөгжлийн бэрхшээлтэй иргэд; орлого багатай малчид; ТТАМ-ын карьер орчмын албан бус газар ашиглагчид	НТХН-ийн Нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн;  Гүйцэтгэгчийн нийгмийн ажилтан
Байгууллага хоорондын уялдаа холбоо	Улирал тутам	Төслийн хэрэгжилтийн явц; Дэлхийн банкны БОНС шаардлагын хэрэгжилт; гомдлын чиг хандлага; замын хөдөлгөөний аюулгүй байдлын үзүүлэлт, зохицуулалтын хамтын ажиллагаа	Албан уулзалт; албан бичиг; зохицуулах дугуй ширээний уулзалт	ЗТЯ; БОУАӨЯ; аймгийн удирдлага; холбогдох яамд	ЗТЯ; НТХН

Логистик болон чадавх бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсгүүд	Судалгааны гол үе шатуудад	Техник, эдийн засгийн үндэслэлийн үр дүн; Бодлого зохицуулалтын шинэчлэл; логистикийн төвүүд; нийлүүлэлтийн сүлжээний туршилтын санаачилгууд	Оролцогч талуудын уулзалт; техникийн дугуй ширээний уулзалт; салбарын зөвлөлдөх уулзалт	Логистикийн компаниуд; ачаа тээврийн компаниуд, төлөөлөл; хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид; зохицуулагч байгууллагууд; хувийн хэвшлийн холбоод	ЗТЯ; Зөвлөхүүд; НТХН
<b>Барилгын дараах үе шат</b>					
Ажил хүлээлцэх ба ашиглалтын эхний үе	Барилгын ажил дуусахаас өмнө болон ашиглалтын эхний жилд	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын сайжруулалт; засвар арчлалтын төлөвлөгөө; урт хугацааны ГБМ; байгаль орчны нөхөн сэргээлтийн байдал	Олон нийтэд мэдээлэх; иргэдийн уулзалт; вэбсайтын шинэчлэл; талбайн үзлэг	Орон нутгийн иргэд; малчид; тээврийн жолооч нар; орон нутгийн удирдлага	ЗТЯ; НТХН
Онцгой байдлын үеийн шуурхай хариу арга хэмжээний бүрэлдэхүүн хэсгийг (CERC) хэрэгжүүлэх тохиолдолд	Шаардлагатай үед	Онцгой байдлын үеийн ажил; түр хугацааны хүндрэл, тасалдал; аюулгүй ажиллагааны арга хэмжээ; төслийн хөрөнгийн дахин хуваарилалт	Шуурхай мэдэгдэл; зохицуулах уулзалт; радио зар; гар утасны мессеж анхааруулга	Нөлөөлөлд өртөх иргэд; орон нутгийн удирдлага; тээврийн жолооч нар	ЗТЯ; НТХН

*Тайлбар: Тодруулсан (bold) үйл ажиллагаанууд нь эмзэг болон давуу бус нөхцөлд байгаа бүлгүүдэд чиглэсэн тусгай оролцооны арга хэмжээнүүд болно.*

#### 4.4 Оролцогч талуудад эргэн мэдээлэх

Төсөл нь ил тод байдал болон хариуцлагыг хангах зорилгоор мэдээлэл солилцох, санал хүсэлтийг эргэн мэдээлэх тогтолцоог хэрэгжүүлнэ.

Оролцогч талуудад дараах сувгуудаар тогтмол мэдээлэл хүргэнэ. Үүнд:

- Сумын түвшинд улирал тутам зохион байгуулах олон нийтийн уулзалт
- Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн жилийн хураангуй тайлан
- ГБМ-ын статистик мэдээлэл (хүлээн авсан, шийдвэрлэсэн, шийдвэрлэгдээгүй гомдлын тоо)
- Нөлөөллийг бууруулах арга хэмжээний үр дүнгийн талаарх мэдээлэл
- ОТХТ-ний хэрэгжилтийн талаарх тайлагнал

ГБМ нь оролцогч талуудаас санал хүсэлт хүлээн авах тасралтгүй суваг болж ажиллана. Итгэлцлийг нэмэгдүүлэх, төслийн хариу арга хэмжээний үр нөлөөг харуулах зорилгоор гомдлын хураангуй мэдээллийг (хувь хүнийг таних боломжтой мэдээлэл оруулахгүйгээр) тогтмол нийтэд мэдээлнэ.

Зөвлөлдөх уулзалтын үеэр санал хүсэлт өгсөн оролцогч талуудад тэдний саналыг хэрхэн харгалзан үзэж, шийдвэрт тусгасан талаар мэдээлнэ. Үүнийг дараах хэлбэрээр хэрэгжүүлж болно. Үүнд:

- Дараагийн шатны уулзалт, зөвлөлдөх арга хэмжээ
- Нөлөөллийг бууруулах арга хэмжээний шинэчлэл
- Албан бичгээр хариу өгөх
- Олон нийтэд зориулсан хураангуй тайлан нийтлэх

Тайлагналын давтамж, агуулга нь төслийн эрсдэлийн түвшинтэй уялдсан байх бөгөөд Дэлхийн банкны БОНС-ын мониторинг, тайлагналын шаардлагад нийцнэ.

#### **4.5 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл түгээх**

Төслийн хэрэгжилтийн хугацаанд дараах баримт бичиг, мэдээллийг олон нийтэд ил тод мэдээлнэ. Үүнд:

- Оролцогч талуудын оролцооны төлөвлөгөө
- Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ
- Багц тус бүрийн Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
- Хөдөлмөрийн менежментийн журам
- Нүүлгэн шилжүүлэлтийн бодлогын хүрээ болон шаардлагатай тохиолдолд талбай тус бүрийн Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө
- Гомдол барагдуулах механизмын журам
- Барилгын ажлын хуваарь болон хөдөлгөөний зохицуулалтын төлөвлөгөө
- Төслийн хэрэгжилтийн явцын тогтмол мэдээлэл
- Байгаль орчин, нийгмийн мониторингийн хураангуй тайлан

Мэдээллийг дараах сувгаар түгээнэ. Үүнд:

- ЗТЯ-ны цахим хуудас
- Аймаг, сумын ЗДТГ
- Орон нутгийн мэдээллийн самбар
- Олон нийтийн зөвлөлдөх уулзалтууд
- Танилцуулах хуудас, товхимол
- Орон нутгийн мэдээллийн хэрэгслүүд (шаардлагатай тохиолдолд радио болон телевиз)
- Багийн Засаг даргаар дамжуулсан шууд мэдээлэл түгээх арга хэмжээ
- Төслийн цахим хуудсууд болон сошиал медиа хуудас

Бүх мэдээллийг Монгол хэлээр олон нийтэд хүргэнэ. Техникийн шинжтэй баримт бичгүүдийн хувьд хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор энгийн, ойлгомжтой хэлээр боловсруулсан хураангуй хувилбарыг бэлтгэнэ.

Эмзэг болон давуу бус нөхцөлд байгаа бүлгүүдийн хувьд мэдээллийг бүрэн ойлгож хүлээн авах боломжийг хангах зорилгоор жижиг бүлгийн уулзалт, өрхөөр хүрч ажиллах зэрэг нэмэлт мэдээлэл түгээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

## 5. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ НӨӨЦ БА ХАРИУЦЛАГА

ОТХТ-г үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүний нөөц, байгууллагын чадавх болон санхүүгийн хангалттай нөөц шаардлагатай. МУТХБЛСТ-ийн хүрээнд оролцогч талуудын оролцоог хангах үйл ажиллагааг төслийн бүрэлдэхүүн хэсэг, замын багц тус бүрийн ажлын цар хүрээ болон байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийн түвшинтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

### 5.1 Нөөц

ЗТЯ нь НТХН-ээр дамжуулан төслийн түвшний оролцогч талуудын оролцооны үйл ажиллагаанд ерөнхий удирдлага, зохицуулалт хийнэ. Багцын түвшинд гүйцэтгэгч байгууллагууд нь тухайн ажлын талбайд хэрэгжүүлэх оролцогч талуудын оролцооны арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэгтэй байх бөгөөд энэхүү үйл ажиллагаанд НТХН болон Хяналтын зөвлөх инженер хяналт тавина.

ОТХТ-ний хэрэгжилттэй холбоотой зардлыг төслийн бүрэлдэхүүн хэсэг 3: Техникийн туслалцаа ба төслийн менежмент болон бүрэлдэхүүн хэсэг 1: Дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хүрээнд гүйцэтгэгчдийн Байгаль орчин, нийгмийн менежментийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Төслийн хэмжээнд оролцогч талуудын оролцооны үйл ажиллагаанд шаардагдах урьдчилсан тооцоот төсвийг доор үзүүлэв. Эдгээр дүн нь зөвхөн урьдчилсан тооцоо бөгөөд төслийн хэрэгжилтийн явцад хэрэгцээ шаардлага, инфляцын түвшин болон бусад хүчин зүйлээс шалтгаалан өөрчлөгдөж болно.

Хүснэгт 5. Оролцогч талуудын оролцооны үйл ажиллагааны урьдчилсан төсөв

Төсвийн ангилал	Тоо хэмжээ	Нэгж зардал (ам.доллар)	Хугацаа/жил	Нэгж зардал (ам.доллар)	Тайлбар
<b>1. Ажилтны цалин болон холбогдох зардал (тооцоолсон)</b>					
1а. НТХН-ийн Нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн (20% хэсэгчилсэн ачаалал)	1	3,380/жил	4 жил	13,521	Хяналт, зохицуулалт
1б. Гүйцэтгэгчийн олон нийттэй харилцах ажилтнууд	6	6,760/жил	3 жил	121,690	Томоохон багц тус бүрт 1
1с. Оролцогч талуудтай ажиллах талбайн томилолтын зардал	Нийт дүн	—	4 жил	20,000	Сумдад хийх талбайн судалгаа
<b>Дэд дүн (1)</b>					<b>155,211</b>
<b>2. Арга хэмжээ</b>					

2a. Иргэдийн зөвлөлдөх уулзалт	40 арга хэмжээ	500	—	20,000	Танхим, материал, зохион байгуулалт
2b. Эмзэг бүлгийн фокус бүлгийн хэлэлцүүлэг	20 арга хэмжээ	800	—	16,000	Эмэгтэйчүүд, ахмад настан, ХБИ
<b>Дэд дүн (2)</b>					<b>36,000</b>
<b>3. Харилцаа холбоо, мэдээлэл түгээх үйл ажиллагаа</b>					
3a. Постер, тараах материал, товхимол	Нийт дүн	—	—	10,000	Disclosure materials
3b. Вэбсайтын хөгжүүлэлт, дижитал шинэчлэл	Нийт дүэ	—	4 жил	3,000	Online disclosure
3c. Мэдээллийн самбар	Багц бүрт хамгийн багадаа 2, томоохон замд 50 км тутам	1500	-	27,000	НТХН-ийн загварын дагуу
<b>Дэд дүн (3)</b>					<b>40,000</b>
<b>4. Сургалтууд</b>					
4a. Байгаль орчин, нийгмийн сургалт (НТХН болон гүйцэтгэгчид)	6 удаа	1,000	—	6,000	Жил бүр
4b. БХМ/БД болон ЖСХ-тэй холбоотой сургалтууд	6 удаа	1,500	—	9,000	Мэргэшсэн сургагч багш
<b>Дэд дүн (4)</b>					<b>15,000</b>
<b>5. Гомдол барагдуулах механизм</b>					
5a. ГБМ хорооны сургалт	15 удаа	500	—	7,500	Сумын түвшний сургалт
5b. Санал хүсэлтийн хайрцаг, засвар үйлчилгээ	30 ширхэг	200	—	6,000	Сумдад байршуулна
5c. ГБМ-ын талаарх тараах материал	Нийт дүн	—	—	10,000	Постер, утасны мэдээлэл
<b>Дэд дүн (5)</b>					<b>23,500</b>
<b>6. Other expenses</b>					
6a. Орчуулга болон хялбаршуулсан хураангуй материал	Нийт дүн	—	—	10,000	Ойлгомжтой хувилбар
6b. Оролцогч талуудын оролцооны бие даасан аудит	1	15,000	—	15,000	Дунд хугацааны үнэлгээ
<b>Дэд дүн (6)</b>					<b>25,000</b>
<b>Нийт дүн: 189,211 ам.доллар (урьдчилсан)</b>					

*Тайлбар: Ажилтнуудын цалин, урамшууллын зардал нь байгууллагын бүтэц, хүний нөөцийн бүрэлдэхүүнээс хамааран өөрчлөгдөж болох тул эдгээр нь урьдчилсан тооцоолол болно.*

## 5.2 Удирдлагын чиг үүрэг ба хариуцлага

ЗТЯ нь НТХН-ээр дамжуулан ОТХТ-г хэрэгжүүлэх, хянах ерөнхий хариуцлагыг хүлээнэ. Дараах хүснэгтэд ОТХТ-г хэрэгжүүлэхэд оролцох гол оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэгтгэн харуулав:

*Хүснэгт 6. ОТХТ-ийг хэрэгжүүлэгч гол талуудын үүрэг, хариуцлагын хураангуй*

НТХН:	Гүйцэтгэгч:	Хяналтын зөвлөх:	Орон нутгийн удирдлага, байгууллагууд:
БОНС 10 шаардлагын хэрэгжилтийг хангах Байгаль орчин, нийгмийн баримт бичгүүдийн ил тод байдлыг хангах Оролцогч талуудын оролцооны бүх бүрэлдэхүүн хэсгийг уялдуулан зохицуулах Гүйцэтгэгчийн оролцооны үйл ажиллагаанд хяналт тавих ГБМ-ийн хэрэгжилтийг хянах Дэлхийн банкинд хүргүүлэх оролцооны тайлагналыг нэгтгэх Эмзэг бүлгийн оролцоог хангах	Олон нийттэй харилцах / нийгмийн ажилтан томилох Гүйцэтгэгчийн ОТХТ боловсруулах, хэрэгжүүлэх Барилгын ажлын өмнөх зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах Барилгын ажлын үеийн оролцооны арга хэмжээг хэрэгжүүлэх Гомдлын бүртгэл хөтлөх Эмзэг бүлэгтэй ажиллах, мэдээлэл хүргэх Ажилчдын Ёс зүйн дүрэм болон олон нийттэй харилцах сургалт зохион байгуулах Барилгын ажлын хуваарийн мэдээллийг цаг тухайд нь өгөх Ажилчдад сургалт явуулах	Гүйцэтгэгчийн ОТХТ хэрэгжилтэд хяналт тавих Баримт бичиг, тайлагналын үнэн зөвийг шалгах ГБМ-ын хэрэгжилтийг хянах Нийцэл зөрчлийг НТХН-д мэдээлж шилжүүлэх	Мэдээлэл түгээх үйл ажиллагааг дэмжих Зөвлөлдөх уулзалтад оролцох Иргэд болон эмзэг бүлэгт мэдээлэл хүргэхэд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн ГБМ хороодыг дэмжих Орон нутгийн түвшний хяналт, мониторинг хийх

## 5.3 Баримтжуулалт ба бүртгэл хөтлөлт

Оролцогч талуудтай хийсэн бүх ажиллагааг дараах байдлаар баримтжуулна. Үүнд:

- Хуралдааны тэмдэглэл, ирцийн жагсаалт (загваруудыг Хавсралтад оруулсан)
- Фото баримтжуулалт (шаардлагатай тохиолдолд)
- Зөвлөлдөх уулзалтын нэгтгэсэн тайлан
- Гомдлын бүртгэл болон шийдвэрлэлтийн тэмдэглэл
- Улирлын оролцогч талуудын оролцооны тайлан
- Хяналт-шинжилгээний хяналтын самбар

Бүх баримт бичгийг НТХН архивлаж хадгалах бөгөөд Дэлхийн банкны явцын хяналт шалгалт, хүсэлтэд бэлэн байлгана.

## 5.4. Оролцогч талуудтай харилцах төлөвлөгөөний заавал мөрдөх доод шаардлага ба хэрэгжилтийн зохицуулалт

ОТХТ-ийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах, бүх барилгын багцуудад нэгдсэн хэрэгжилтийг бий болгох зорилгоор гүйцэтгэгч, НТХН, болон хяналт хэрэгжүүлэгч байгууллагуудад дараах доод шаардлагууд заавал мөрдөгдөнө. Эдгээр нь заавал биелүүлэх нөхцөл бөгөөд багцын түвшний гүйцэтгэгчийн БОНМТ болон гэрээний үүрэгт тусгагдана.

#### **5.4.1 Ажил эхлүүлэхийн өмнөх нөхцөлүүд**

Барилгын ажил дараах нөхцөл бүрэн хангагдаж, баримтжуулагдсан тохиолдолд л эхлүүлнэ. Үүнд:

а. Нөлөөлөлд өртсөн сум бүрт урьдчилсан зөвлөлдөх уулзалт зохион байгуулагдсан байна. Үүнд:

- Барилгын ажлын хуваарийг танилцуулах,
- Замын хөдөлгөөний зохицуулалт,
- Малын гарц, нэвтрэх боломж
- Байгаль орчин ба нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээ
- ГБМ-ын журам

б. Олон нийтэд харагдахуйц газруудад болон талбай дээр мэдээллийн самбар суурилуулсан байх бөгөөд үүнд:

- Гүйцэтгэгч байгууллагын нэр, холбоо барих мэдээлэл
- НТХН-ийн холбоо барих мэдээлэл
- ГБМ өргөдөл гаргах сувгууд
- Гол ажлын үе шатны мэдээлэл

с. Багц тус бүрийн БОНМТ болон ГБМ-ын журмыг сумын ЗДТГ болон цахим сувгуудаар (боломжтой тохиолдолд) нийтэд ил болгосон байх.

Эдгээр үйл ажиллагааны нотлох баримтыг ажил эхлүүлэх зөвшөөрөл олгохоос өмнө НТХН-д хүргүүлнэ.

#### **5.4.2 Олон нийтийн оролцооны хамгийн бага шаардлага**

Бүх идэвхтэй барилгын багцуудад:

а. Нөлөөлөлд өртсөн сум бүрт улиралд багадаанэг удаа олон нийтийн зөвлөлдөх уулзалт хийнэ.

б. Сум бүрт:

- Ажлын өмнө эмзэг бүлгүүдтэй багадаанэг фокус бүлгийн хэлэлцүүлэг,
- Барилгын явцад жилд багадаанэг нэмэлт фокус бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулна.

с. Шууд нөлөөлөлд өртсөн өрх, бизнес бүртэй дараах нөхцөлд заавал ганцаарчилсан зөвлөлдөөн хийнэ.

- Түр хугацааны нэвтрэх хязгаарлалт тогтоох,
- Хөрс хуулалт болон ТТАМ-ын карьер ашиглах,
- Бизнесийн үйл ажиллагааны нэвтрэлтийн хязгаарлалт

Хэрэв олон нийтийн оролцооны хамгийн бага шаардлагыг хангаагүй тохиолдолд залруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж НТХН-д ирүүлнэ.

### **5.4.3 Карьер болон түр газар ашиглалтын талаарх зөвлөлдөх үйл ажиллагаа**

Дараах нөхцөл бүрэн хангагдаагүй тохиолдолд ТТАМ-ын карьер, олборлох талбай, хаягдал материалын овоолгын талбай болон түр шороон материал ашиглалтын бүсийг ашиглахыг хориглоно. Үүнд:

- Бэлчээр болон газар ашиглагчидтай урьдчилан зөвлөлдөх,
- Албан бус газар ашиглалтын зохицуулалтыг (холбогдох тохиолдолд) баримтжуулах,
- Нөхөн сэргээх болон нөхөн сэргээлтийн арга хэмжээг танилцуулсан байх
- ГБМ-д хандах боломжийг бүрэн хангасан байх

Зөвлөлдөх уулзалтууд болон холбогдох баримт бичгийг гүйцэтгэгчийн БОНМТ-нд хавсаргаж, хяналт шалгалт болон аудитын зорилгоор хадгална.

### **5.4.4 Санал, гомдол шийдвэрлэх гүйцэтгэлийн үзүүлэлт**

Санал, гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх зорилгоор дараах гүйцэтгэлийн стандартыг мөрдөнө. Үүнд:

- Бүх санал, гомдлыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор бүртгэнэ.
- Санал, гомдлыг хүлээн авсныг өргөдөл гаргагчид ажлын 2 өдрийн дотор мэдэгдэнэ.
- Нийт санал, гомдлын багадаа 80 хувийг ажлын 20 өдрийн дотор шийдвэрлэсэн байна.
- Шийдвэрлэх хугацаа хэтэрсэн тохиолдолд асуудлыг НТХН-д шат ахиулан шилжүүлнэ.
- Гомдол шийдвэрлэлтийн гүйцэтгэл дараалсан хоёр улиралд 80 хувиас доош гарсан тохиолдолд албан ёсны үнэлгээ хийж, залруулах арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлнэ.

Гомдол шийдвэрлэлтийн гүйцэтгэлийг НТХН улирал тутам хянаж, ЗТЯ-ны удирдлагад тайлагнана.

### **5.4.5 БХМ/БД-ын эрсдэлийг бууруулах шаардлага**

Нууцлал хангасан гомдол барагдуулах сувгаас гадна дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Бүх гүйцэтгэгчид БХМ/БД-тай холбоотой заалтуудыг тусгасан Ажилтны ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлнэ.
- Ажил эхлэхээс өмнө ажилтны ёс зүй, БХМ/БД-аас урьдчилан сэргийлэх талаар заавал танилцуулах сургалт зохион байгуулна.
- Барилгын ажлын эхний үе шатанд олон нийтэд ажилтны ёс зүй, мэдээлэх сувгуудын талаар мэдээлэл түгээх, таниулах уулзалтууд зохион байгуулна.
- БХМ/БД-тэй холбоотой өргөдөл, гомдлыг хохирогч төвтэй, нууцлал хангасан журмаар шийдвэрлэх бөгөөд ердийн өргөдөл, гомдол шийдвэрлэх хороогоор хэлэлцэхгүй.

#### **5.4.6 Тайлагнал ба баримтжуулалтын шаардлага**

Гүйцэтгэгч дараах баримт бичгийг бэлтгэн ирүүлнэ. Үүнд:

- Сар бүрийн оролцогч талуудын оролцооны үйл ажиллагааны бүртгэл;
- Сар бүрийн гомдлын бүртгэл;
- Улирлын ОТХТ-ний хэрэгжилтийн тайлан;
- Оролцогчдын ирцийн бүртгэл (хүйсээр ангилсан);
- Эмзэг бүлгийн иргэдэд чиглэсэн оролцооны үйл ажиллагааны баримтжуулалт.

Хяналтын зөвлөх нь талбайн хяналт шалгалтын үеэр эдгээр бүртгэл, мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулна.

#### **5.4.7 Үл нийцэл ба залруулах арга хэмжээ**

Энэхүү ОТХТ-д заасан хамгийн бага шаардлагууд хангагдаагүй тохиолдолд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Гүйцэтгэгч нь тодорхой хугацаатай залруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.
- Үл нийцэл үргэлжилсэн тохиолдолд гэрээний нөхцөлд заасан арга хэмжээг хэрэгжүүлж болно.
- Оролцогч талуудын оролцоотой холбоотой үүргээ удаа дараа биелүүлээгүй тохиолдлыг ЗТЯ-ны удирдлагын түвшинд шилжүүлэн шийдвэрлүүлнэ.

### **6. ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ**

ГБМ-ын үндсэн зорилго нь төслийн хэрэгжилттэй холбоотой өргөдөл, гомдол, санал хүсэлтийг бүх талын сэтгэл ханамжийг хангахуйц, цаг тухайд нь, үр дүнтэй, ил тод, соёлын онцлогт нийцсэн байдлаар шийдвэрлэхэд оршино.

ГБМ нь төслийн нөлөөлөлд өртсөн иргэд болон бусад оролцогч талуудад байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, барилгын ажлын үйл ажиллагаа, нэвтрэх боломжийн хязгаарлалт, хөдөлмөр эрхлэлт болон МУТХБЛСТ-ийн хэрэгжилттэй холбоотой бусад асуудлаар санал, гомдол гаргах хүртээмжтэй, оролцоог хангасан сувгуудыг бүрдүүлнэ.

Энэ нь Дэлхийн банкны БОНС10 болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн шаардлагын дагуу боловсруулагдсан бөгөөд ямар нэг үнэ төлбөргүйгээр ажиллана. Энэхүү механизм нь гомдол гаргагчийн шүүхийн болон захиргааны журмаар эрхээ хамгаалуулах боломжийг хязгаарлахгүй.

## 6.1. ГБМ-ын тайлбар

### Хүснэгт 7. ГБМ-ын үйл явц

Үе шат	Үйл явцын тайлбар	Хугацаа	Хариуцагч
<b>ГБМ-ын хэрэгжилтийн бүтэц</b>	<p>ГБМ нь дараах гурван түвшинд ажиллана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Орон нутгийн түвшин (сум/дэд төслийн түвшин) – Анхан шатны хүлээн авах цэг бөгөөд Гүйцэтгэгчийн олон нийттэй харилцах ажилтан болон орон нутгийн ГБМ-ын хариуцсан ажилтан хариуцна.</li> <li>Төслийн түвшин (НТХН) – Хяналт болон шат ахиулан шийдвэрлэх түвшин бөгөөд НТХН-ийн Байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүд хариуцна.</li> <li>Үндэсний түвшин (ЗТЯ) – Давж заалдах болон бодлогын хяналтын түвшин. Шаардлагатай тохиолдолд өргөдөл, гомдлыг Дэлхийн банкны ГШҮ-нд шилжүүлэн шийдвэрлүүлж болно.</li> </ul>	Тасралтгүй	ЗТЯ, НТХН, Гүйцэтгэгчид
<b>Өргөдөл, гомдол хүлээн авах</b>	<p>Өргөдөл, гомдлыг дараах сувгаар хүлээн авна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>Шуурхай утас</li> <li>Төслийн албан ёсны утас</li> <li>Гар утасны мессэж үйлчилгээ</li> <li>Цахим шуудан</li> <li>Орон нутгийн ГБМ хариуцсан ажилтанд хаягласан албан бичиг</li> <li>Гомдлын маягт (сум болон талбайн оффист байршуулна)</li> <li>Санал хүсэлтийн хайрцаг</li> <li>Биечлэн ирүүлсэн хүсэлт (гомдлын бүртгэлийн дэвтэрт бүртгэнэ)</li> </ul>	Тасралтгүй	Гүйцэтгэгчийн орон нутгийн харилцааны ажилтан, Нийгмийн ажилтан, НТХН, орон нутгийн захиргаа, ГБМ-ын хариуцсан ажилтнууд, 1111 төв, ЗТЯ-ны веб
<b>Ангилан бүртгэх, боловсруулах</b>	<p>Өргөдөл, гомдлыг Гүйцэтгэгчийн Нийгмийн ажилтанд шилжүүлж, төвлөрсөн бүртгэлд оруулна. Ангилал:</p> <ul style="list-style-type: none"> <li>Ерөнхий</li> <li>Байгаль орчны (тоосжилт, дуу чимээ, хог хаягдал, бохирдол)</li> <li>Нийгмийн (гарц, газар ашиглалт, малын шилжилт хөдөлгөөн, аюулгүй байдал)</li> <li>Замын хөдөлгөөний аюулгүй байдал</li> <li>Хөдөлмөрийн асуудал</li> <li>БМХ/БД</li> <li>Бусад</li> </ul>	Хүлээн авмагц	Орон нутгийн ГБМ хариуцсан ажилтан
<b>Хүлээн авсны баталгаажуулалт</b>	Өргөдөл гаргагчид аман болон бичгээр (гар утасны мессеж, цахим шуудан, албан бичиг, веб мэдэгдэл гэх мэт) хүлээн авсныг мэдэгдэнэ.	Ажлын 2 хоногт	Орон нутгийн ГБМ хариуцсан ажилтан
<b>Нягтлан шалгах, судлах</b>	Судалгаа, шалгалтыг Гүйцэтгэгч болон Хяналтын зөвлөх хамтран хийнэ. Ноцтой эсвэл шийдвэрлэгдээгүй асуудлыг НТХН хариуцан шалгана. Шийдвэрлэх санал боловсруулж өргөдөл гаргагчид хүргэнэ.	Ажлын 10 хоногт	Гүйцэтгэгч, Хяналтын зөвлөх, НТХН

<b>Шийдвэрлэх, арга хэмжээ авах</b>	Залруулах арга хэмжээг хэрэгжүүлж, өргөдөл гаргагчид шийдвэрийг мэдэгдэнэ.	Ажлын 20 хоногт (нарийн төвөгтэй тохиолдлоос бусад)	Гүйцэтгэгч, НТХН
<b>Хяналт-шинжилгээ, үнэлгээ</b>	ГБМ-ын мэдээллийг улирлын тайланд нэгтгэн ЗТЯ, Дэлхийн банк болон холбогдох талуудад хүргүүлнэ.	Улирал тутам	НТХН-ийн Нийгмийн мэргэжилтэн
<b>Санал хүсэлтийн цуглуулалт</b>	Өргөдөл гаргагчийн сэтгэл ханамжийг утсаар болон бичгээр баталгаажуулан бүртгэнэ.	Шийдвэрлэсний дараа	Гүйцэтгэгч, НТХН
<b>Давж заалдах шат</b>	Өргөдөл гаргагч шийдвэрт сэтгэл хангалуун бус бол НТХН эсвэл ЗТЯ-ны түвшинд шат ахиулан шийдвэрлүүлэх эрхтэй. Эцсийн шатанд шүүх болон Дэлхийн банкны ГШҮ-д хандаж болно.	Сэтгэл ханамжгүй байгаа гэж үзсэн тохиолдолд 10 хоногийн дотор	НТХН, ЗТЯ
<b>Сургалт</b>	НТХН-ийн ажилтнууд, хяналтын зөвлөхүүд, ГБМ-ын хариуцсан ажилтнууд, орон нутгийн захиргаа, ЗТЯ, Гүйцэтгэгч болон Хяналтын зөвлөхүүдэд дараах сургалтыг зохион байгуулна. <ul style="list-style-type: none"> <li>ГБМ-ын ерөнхий үйл ажиллагаа</li> <li>Өргөдөл, гомдлын бүртгэл, тайлагнал</li> </ul>	Ажил эхлэхээс өмнө	НТХН

Монгол Улсын Засгийн газар болон Дэлхийн банк нь төслийн үйл ажиллагаатай холбоотой санал, гомдол гаргасан эсвэл үзэл бодлоо илэрхийлсэн оролцогч талуудын эсрэг аливаа хэлбэрийн дарамт шахалт, өшөө авалт, ялгаварлан гадуурхалтыг үл зөвшөөрнө.

Бүх өргөдөл гаргагчтай хүндэтгэлтэй, шударга харьцана. Нэрээ нууцалсан өргөдөл, гомдлыг мөн хүлээн авч шийдвэрлэнэ.

## 7. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ТАЙЛАГНАЛ

### 7.1 ОТХТ-ний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, тайлагналын тойм

ОТХТ-ний хэрэгжилтэд ЗТЯ-ны НТХН хяналт тавих бөгөөд Гүйцэтгэгч болон Хяналтын зөвлөхүүд дэмжлэг үзүүлнэ. Хяналт-шинжилгээ нь дараах хоёр үндсэн чиглэлд төвлөрнө. Үүнд:

- Оролцогч талуудын оролцооны үйл ажиллагааны тоон болон чанарын үзүүлэлтүүд;
- ГБМ-ын үр нөлөө.

ОТХТ-ний хэрэгжилтийн үр дүнтэй байдлыг хангах зорилгоор дараах үзүүлэлтүүдийг тогтмол хянаж бүртгэнэ.

#### Хүснэгт 8. Оролцогч талуудын оролцооны хяналт-шинжилгээний үзүүлэлтүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Давтамж	Хариуцах байгууллага	Хамгийн бага шаардлага
<b>А. Оролцогч талуудын оролцооны үйл ажиллагаа</b>					
1	Олон нийтийн зөвлөлдөх уулзалтын тоо (багц болон улирлаар)	Тоо	Улирал тутам	Гүйцэтгэгч; НТХН	Сум бүрт барилгын ажил эхлэхээс өмнө багадаа 1 удаагийн уулзалт зохион байгуулах бөгөөд барилгын ажлын хугацаанд багц тус бүрт улиралд 1 олон нийтийн уулзалт зохион байгуулна.

2	Эмзэг бүлгийн иргэдтэй зохион байгуулсан зорилтот бүлгийн хэлэлцүүлгийн тоо (эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бага орлоготой малчид)	Тоо	Улирал тутам	Гүйцэтгэгчийн Нийгмийн ажилтан; НТХН-ийн Нийгмийн мэргэжилтэн	Ажил эхлэхээс өмнө сум бүрт эмзэг бүлгийн иргэдтэй багадаа 1 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, барилгын ажлын хугацаанд жил бүр багадаа 1 нэмэлт хэлэлцүүлэг зохион байгуулна (эмзэг бүлгийн иргэд байгаа тохиолдолд).
3	Шууд нөлөөлөлд өртсөн өрх, аж ахуйн нэгжтэй хийсэн ганцаарчилсан уулзалтын тоо	Тоо	Улирал тутам	Гүйцэтгэгч; НТХН	Түр хугацааны нэвтрэх боломжийн хязгаарлалт, ТТАМ-ын карьер ашиглалтад оруулах, эсвэл бизнесийн үйл ажиллагаанд саад учруулахаас өмнө заавал ганцаарчилсан уулзалт зохион байгуулна. Шууд нөлөөлөлд өртсөн өрхүүдийн 100 хувийг хамруулсан байна.
4	Байгууллага хоорондын уялдаа холбооны уулзалтын тоо (яамд, аймаг, сумын байгууллагууд)	Тоо	Улирал тутам	ЗТЯ; НТХН	Барилгын ажлын үед багц бүрийн хувьд аймгийн түвшинд улирал тутам багадаа 1 удаагийн зохицуулалтын уулзалт зохион байгуулна.
5	Гүйцэтгэгчийн хэрэгжүүлсэн оролцогч талуудын оролцооны үйл ажиллагааны тоо (нийт мэдээлэл хүргэх үйл ажиллагаа)	Тоо	Сар бүр / Улирал тутам	Гүйцэтгэгч; Хяналтын зөвлөх	Сар бүр оролцогч талуудын оролцооны бүртгэл хөтөлнө. Багц бүрт сард багадаа 2 баримтжуулсан мэдээлэл түгээх үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.
<b>Б. Оролцоо ба хүртээмж</b>					
6	Оролцогч талуудын оролцооны үйл ажиллагаанд оролцсон нийт хүний тоо	Хүн	Улирал тутам	Гүйцэтгэгч; НТХН	Оролцогчдын бүтэц нь нөлөөлөлд өртсөн орон нутгийн хүн амын бүтцийг төлөөлсөн байна. Албан ёсны бүх уулзалтад ирцийн бүртгэл заавал хөтөлнө.
6	Үүнээс: эмэгтэйчүүд	Хүн	Улирал тутам	Гүйцэтгэгч; НТХН	Боломжтой тохиолдолд ерөнхий уулзалтад оролцогчдын багадаа 30 хувь нь эмэгтэй байна. Хангалттай оролцоо хангагдаагүй тохиолдолд тусгай уулзалт зохион байгуулна.
6	Үүнээс: эмзэг бүлгийн иргэд	Хүн	Улирал тутам	Гүйцэтгэгч; НТХН	Эмзэг бүлгийн оролцоог тусад нь бүртгэнэ. Тэдний оролцоо хүн амын бүтцэд эзлэх хувиас доогуур байвал нэмэлт зорилтот үйл ажиллагаа зохион байгуулна.
6	Нөлөөлөлд өртсөн иргэдийн оролцооны түвшин (уригдсан оролцогчдоос хүрэлцэн ирсэн хувь)	Хувь	Улирал тутам	НТХН	Зөвлөлдөх уулзалтад уригдсан шууд нөлөөлөлд өртсөн өрхүүдийн багадаа 50 хувь нь төлөөлөлтэй оролцсон байна.
<b>В. Мэдээллийн ил тод байдал</b>					
7	Төслийн талбайд байршуулж, тогтмол шинэчилж буй мэдээллийн самбарын тоо	Тоо	Улирал тутам	Гүйцэтгэгч; Хяналтын зөвлөх	Багц тус бүрт багадаа 2 мэдээллийн самбар (эсвэл урт коридорын хувьд 50 км тутамд 1) байршуулна. Самбарт ГБМ-ын холбоо барих мэдээлэл, барилгын ажлын хуваарь, гүйцэтгэгчийн холбоо барих мэдээллийг тусгаж, шаардлагатай үед шинэчилнэ.

8	Ил тод мэдээлсэн төслийн баримт бичгийн тоо (БОНМТ, ГБМ журам, барилгын ажлын хуваарь, шинэчлэлтүүд)	Тоо	Улирал тутам	НТХН	Багц тус бүрийн БОНМТ болон ГБМ-ын журмыг ажил эхлэхээс өмнө ил тод мэдээлсэн байна. Замын хөдөлгөөний томоохон өөрчлөлтөөс багадаа 2 долоо хоногийн өмнө барилгын ажлын хуваарийн шинэчлэлтийг мэдээлнэ.
9	Түгээсэн мэдээллийн материалын тоо (гарын авлага, зар мэдээ, хэвлэлийн мэдээ, сошиал медиа мэдээлэл)	Тоо	Улирал тутам	Гүйцэтгэгч; НТХН	Барилгын ажлын томоохон үе шатны өөрчлөлт болон зам хаах үйл ажиллагаанаас өмнө багадаа 1 удаа олон нийтэд мэдээлнэ.
<b>Г. Санал хүсэлт ба өргөдөл, гомдлын менежмент</b>					
10	Хүлээн авсан санал хүсэлтийн тоо (өргөдөл, гомдлоос бусад санал, зөвлөмж)	Тоо	Улирал тутам	НТХН	Зөвлөлдөх уулзалтаар гарсан бүх санал хүсэлтийг бүртгэж, хянана. Улирал тутам санал-хариу арга хэмжээний матриц боловсруулна.
11	Хүлээн авсан өргөдөл, гомдлын тоо (төрлөөр ангилсан)	Тоо	Сар бүр / Улирал тутам	Гүйцэтгэгч; НТХН	Бүх өргөдөл, гомдлыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор төвлөрсөн ГБМ-ын бүртгэлд оруулсан байна.
12	Тогтоосон хугацаанд шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо	Тоо	Улирал тутам	Гүйцэтгэгч; НТХН	Өргөдөл, гомдлын багадаа 80 хувийг ажлын 20 өдрийн дотор шийдвэрлэсэн байна.
13	Өргөдөл, гомдол шийдвэрлэхэд зарцуулсан дундаж хугацаа	Өдөр	Улирал тутам	НТХН	Дундаж хугацаа ажлын 20 өдрөөс хэтрэхгүй байна.
14	Хугацаанд нь шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын хувь	%	Улирал тутам	НТХН	Зорилтот түвшин $\geq 80\%$ . Хэрэв хоёр улирал дараалан энэ босгоос доогуур байвал шат ахиулан авч үзнэ.
15	Өргөдөл, гомдол шийдвэрлэлтэд сэтгэл хангалуун байгаа өргөдөл гаргагчдын хувь	%	Улирал тутам	НТХН	Сэтгэл ханамжийн түвшин багадаа 70 хувь байна. Үүнээс доош бол залруулах үнэлгээ хийнэ.
<b>Д. Чанар ба гүйцэтгэлийн үзүүлэлтүүд</b>					
16	Зөвлөлдөх уулзалтаас гарсан саналын дагуу хэрэгжүүлсэн залруулах арга хэмжээний тоо	Тоо	Улирал тутам	Гүйцэтгэгч; НТХН	Зөвлөлдөх уулзалтаар тохирсон бүх бууруулах арга хэмжээг тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, баримтжуулсан байна.
17	Олон нийтийн төлөөлөлтэй хамтран зохион байгуулсан талбайн хяналт шалгалтын тоо	Тоо	Улирал тутам	Гүйцэтгэгч; Хяналтын зөвлөх; НТХН	Идэвхтэй багц бүрт улирал тутам багадаа 1 хамтарсан талбайн үзлэг зохион байгуулна.
18	Нууц сувгаар шилжүүлэн шийдвэрлэсэн БХМ/БД-тай холбоотой өргөдөл, гомдлын тоо (зөвхөн нэгтгэсэн байдлаар тайлагнана)	Тоо	Улирал тутам	НТХН (нууц тайлагнал)	БХМ/БД-тай холбоотой бүх тохиолдлыг 24 цагийн дотор нууцлал хариуцсан ажилтан болон холбогдох үйлчилгээ үзүүлэгч байгууллагад шилжүүлнэ. Өшөө авалт, дарамт шахалтыг үл тэвчинэ.

Гүйцэтгэгч байгууллагууд оролцогч талуудтай харилцах үйл ажиллагаа болон хүлээн авсан санал, гомдлын талаарх сарын тайланг НТХН ирүүлнэ. НТХН нь энэхүү мэдээллийг нэгтгэн боловсруулж, ЗТЯ-ны удирдлага болон Дэлхийн банкинд хүргүүлэх хагас жилийн байгаль орчин, нийгмийн хяналт-шинжилгээний тайланд тусгана.

Шаардлагатай тохиолдолд оролцогч талууд (тухайлбал орон нутгийн захиргааны байгууллагууд болон олон нийтийн төлөөлөгчид) хамтарсан талбайн үзлэг хийх, хяналт-шинжилгээний уулзалтад оролцох, гомдолтой холбоотой залруулах арга хэмжээний хэрэгжилтийг баталгаажуулах зэрэг үйл ажиллагаагаар дамжуулан мониторингийн үйл явцад оролцож болно.

## **7.2 Оролцогч талуудад хариу мэдээлэх**

Төслийн хэрэгжилтийн явцад хэрэгжүүлж буй үйл ажиллагааны өөрчлөлт, оролцогч талуудаас ирүүлсэн санал хүсэлт, мөн хэрэгжилтийн явцад олж авсан сургамжийг тусгах зорилгоор ОТХТ-г шаардлагатай тохиолдолд тогтмол хянаж, шинэчилнэ.

Олон нийтээс ирүүлсэн гомдол, санал хүсэлт, лавлагаа болон холбогдох тохиолдлуудын талаарх сар, улирал, хагас жилийн нэгтгэсэн дотоод тайланг тэдгээртэй холбоотой залруулах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийн хамт НТХН-ийн хариуцсан ажилтнууд боловсруулж, ЗТЯ-ны удирдлагад хүргүүлнэ. Эдгээр тайлан нь дараах асуудлуудыг үнэлэх үндэс суурь болно. Үүнд:

- Хүлээн авсан гомдлын тоо болон төрөл;
- Давтагдан гарч буй асуудлуудын хандлага;
- Гомдол шийдвэрлэлтийн шуурхай байдал;
- Залруулах арга хэмжээний үр нөлөө;
- Оролцогч талуудын оролцооны үйл ажиллагааны ерөнхий үр дүн.

Жилийн хугацаанд хэрэгжүүлсэн олон нийтийн оролцоо, зөвлөлдөх үйл ажиллагааны талаарх мэдээллийг оролцогч талуудад дараах сувгуудаар хүргэж болно. Үүнд:

- ЗТЯ-ны цахим хуудсанд мэдээлэл нийтлэх;
- Аймаг, сумын түвшний олон нийтийн уулзалт зохион байгуулах;
- Олон нийтийн зөвлөлдөх уулзалтууд зохион байгуулах;
- Барилгын талбай дахь мэдээллийн самбаруудаар мэдээлэл түгээх;
- Баг, сумын удирдлагаар дамжуулан мэдээлэл хүргэх.

Боломжтой тохиолдолд гомдлын статистик мэдээлэл болон оролцогч талуудын оролцооны үр дүнгийн талаарх хураангуй мэдээллийг (хувийн мэдээллийг хассан байдлаар) олон нийтэд нээлттэй хүргэж, ил тод байдлыг нэмэгдүүлэх, олон нийтийн итгэлийг бэхжүүлэхэд ашиглана.

## ХАВСРАЛТ 1: ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ТОДОРХОЙЛОЛТ, ШИНЖИЛГЭЭ

Оролцогч тал	Үүрэг ба зорилго	Сонирхол	Нөлөө
Дэлхийн Банк	Төслийн санхүүжилт; БОНС хэрэгжилтийн хяналт; гарц материалын хянан баталгаа; хяналт-шинжилгээний айлчлал	Өндөр	Өндөр
ЗТЯ	Хэрэгжүүлэгч байгууллага; бодлогын удирдлага; дэд бүтцийн хэрэгжилт; БОНС болон үндэсний хууль тогтоомжийн нийцэл	Өндөр	Өндөр
НТХН	Өдөр тутмын төслийн удирдлага; оролцогч талуудын оролцоо; байгаль орчин ба нийгмийн мониторинг; гомдлын механизмын хяналт	Өндөр	Өндөр
Замын тээврийн хөгжлийн төв	Замын хөрөнгийн менежмент; засвар арчлалтын төлөвлөлт; техникийн хяналт	Өндөр	Өндөр
Сангийн яам	Зээл, санхүүгийн удирдлага; төсвийн хяналт	Өндөр	Өндөр
БОУАӨЯ	БОНУ батлах; байгаль орчны мониторинг; зохицуулалтын хэрэгжилт	Өндөр	Өндөр
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	Нийлүүлэлтийн сүлжээний хөгжил; сүүлийн милийн холболт; хөдөө аж ахуйн ложистикийн үр ашиг	Өндөр	Дунд
Үндэсний хөгжлийн агентлаг / Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Салбар хоорондын зохицуулалт; стратегийн уялдаа	Дунд	Өндөр
Аймгийн Засаг даргын тамгын газар	Орон нутгийн зохицуулалт; зөвлөлдөх уулзалт дэмжих; гомдлын дэмжлэг; бүс нутгийн хяналт	Өндөр	Өндөр
Сумын Засаг даргын тамгын газар	Орон нутгийн түвшний зохицуулалт; мэдээлэл түгээх; гомдлын зуучлал	Өндөр	Дунд
Байгаль орчны байгууллагууд (үндэсний ба орон нутгийн)	Байгаль орчны нийцлийн хяналт; бууруулах арга хэмжээг шалгах	Өндөр	Дунд
Тосон Хулстай, Хөгнө Тарна, Хангайн Нуруу, Тарвагтай Нурууны байгалийн цогцолборт газрын захиргаад	Байгаль орчны мониторинг; арга хэмжээний хяналт; зөвлөлдөх уулзалтад оролцох; хяналт	Дунд	Дунд
Зам дагуух орон нутгийн иргэд	Барилгын нөлөөлөлд өртөгч; замын сайжруулалтын шууд нөлөөлөл	Өндөр / Нөлөөлөлд өртсөн	Дунд
Малчид, мал бүхий өрхүүд	Малын хөдөлгөөний хязгаарлалт, бэлчээр ашиглалт, түр замын нөлөөлөл; сайжруулсан хүртээмжийн ашиг хүртэгч	Өндөр	Дунд
Алслагдсан малчин өрхүүд (малчдыг холбох орон нутгийн зам)	Холболтын сайжралтаас ашиг хүртэгч; хүртээмж ба аюулгүй байдлын асуудал	Өндөр / Нөлөөлөлд өртсөн	Бага-Дунд

Хаягдал материал хадгалалтын/овоолгын бүсийн ойролцоох өрхүүд	Түр газар ашиглалтын нөлөөлөл; байгаль орчны асуудал	Өндөр / Нөлөөлөлд өртсөн	Бага–Дунд
Зам дагуух жижиг бизнес эрхлэгчид	Хүртээмжийн тасралтгүй байдал; ашигтай байдал; замын урсгал нэмэгдэхээс олох ашиг	Өндөр / Нөлөөлөлд өртсөн	Дунд
Тээврийн операторууд (ачааны болон зорчигч тээвэр)	Замын хөдөлгөөний аюулгүй байдал; зорчих хугацаа; түр саатал	Өндөр / Нөлөөлөлд өртсөн	Дунд
Түр болон улирлын замын хэрэглэгчид	Барилгын үеийн аюулгүй байдал; чиглүүлэлт	Дунд	Бага
Барилгын ажилчид (туслан гүйцэтгэгчид орно)	Хөдөлмөрийн нөхцөл; ХАБЭА; хөдөлмөрийн харилцаа	Өндөр / Нөлөөлөлд өртсөн	Хувь хүний хувьд бага (нийтдээ дунд)
Кемпийн ажилчид	Орон сууц, хамтын амьдрал; олон нийттэй харилцаа	Дунд	Бага
Логистикийн компаниуд ба ачаа тээвэрлэгчид	Үр ашгийн сайжрал; зохицуулалтын өөрчлөлт	Өндөр / Нөлөөлөлд өртсөн	Дунд–Өндөр
Хөдөө аж ахуйн үйлдвэрлэгчид ба махны сүлжээ	Логистикийн сайжрал; малчдыг холбох орон нутгийн замын сүлжээ	Өндөр	Дунд
Гүйцэтгэгч болон дэд гүйцэтгэгчид	Ажлын гүйцэтгэл; бууруулах арга хэмжээний хэрэгжилт	Өндөр	Өндөр
Хяналтын инженерүүд	Гүйцэтгэлийн хяналт; байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хэрэгжилтийн хяналт	Өндөр	Дунд–Өндөр
Байгаль орчны ТББ-ууд	Байгаль орчны нөлөөллийн хяналт; хамгаалалт	Дунд–Өндөр	Дунд
Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ТББ-ууд	Осол бууруулах; аюулгүй байдлын сайжруулалт	Дунд	Дунд
Малчдын холбоо / хоршоо	Бэлчээрийн хүртээмж; гарц, гарцын зохицуулалт	Өндөр	Дунд
Эмэгтэйчүүдийн холбоо	Эмзэг бүлгийн төлөөлөл; аюулгүй байдал; тэгш хүртээмж	Дунд	Бага–Дунд
Үйлдвэрчний эвлэл (байгаа тохиолдолд)	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн эрх зүйн асуудал	Дунд	Дунд
Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд	Тээврийн төлөвлөлт; байгаль орчны мониторинг; өгөгдөл	Дунд	Бага
Бие даасан, эрдэмтэн судлаачид (жишээ нь шувуу ажиглагчид)	Биологийн олон янз байдлын нөлөөлөл	Бага–Дунд	Бага
Бусад хөгжлийн түншүүд	Бодлогын уялдаа; салбарын шинэчлэл	Дунд	Дунд

## ХАВСРАЛТ 2: ӨМНӨ ХИЙГДСЭН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ОРОЛЦООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

(Дэлхийн банкны үнэлгээнээс өмнө – 2021 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар)

Оролцогч тал	Хэлэлцсэн сэдвүүд	Гол санал / товч дүгнэлт
<p>Гүйцэтгэх/ хэрэгжүүлэгч байгууллага – ЗТЯ болон авто зам хариуцагч байгууллагууд</p>	<p>Төслийн ерөнхий концепц; БОНС-ын шаардлага; БОНМХ болон БОНМТ-ний төсөл боловсруулах; оролцогч талуудын оролцооны арга барил</p> <p>Огноо: 2021 оны 3–6 сар</p> <p>Хэлбэр: Техникийн тогтмол уулзалт, уялдаа холбоо, зохион байгуулалтыг хангах</p>	<ul style="list-style-type: none"> <li>• ЗТЯ-ны холбогдох албан тушаалтнуудад тогтмол мэдээлэл өгсөн.</li> <li>• Сонгосон болон боломжит авто замын байршил, үр шимийг хүртэгч бүс нутгуудтай холбоотой судалгаа болон техникийн өгөгдлийг солилцсон.</li> </ul>
<p>Үндэсний болон орон нутгийн ТББ-ууд (бэлчээрийн менежментийн бүлгүүд, замын хяналтын ТББ-ууд, малчдын хоршоо, байгаль орчны ажилтнууд, эмэгтэй тэргүүнтэй бизнесийн холбоод, хувийн хэвшлийн төлөөлөл, хөгжлийн түншүүд)</p>	<p>Төслийн ерөнхий концепц; байгаль орчин, нийгмийн эрсдэл ба нөлөөлөл; авто замын зураг төсөл; логистикийн холболт</p> <p>Огноо: 2021 оны 6 сарын 18</p> <p>Хэлбэр: Онлайн уулзалт (8 оролцогч)</p>	<p>Төслийн үр дүн, замын зураг төсөл ба байгаль орчны нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Оролцогчид төслийн үр дүн ерөнхийдөө эерэг хөгжил авчирна гэж үзсэн бөгөөд зам сонголтын шалгуур болон логистикийн уялдаа холбоог сонирхсон.</li> <li>• Говь, хээр, мөнх цэвдэгтэй бүсэд өөр өөр хийцийн замын зураг төсөл шаардлагатай гэж үзсэн. Өмнөх туршлагад уур амьсгал, байгаль орчны эрсдэлийг хангалттай тооцоогүй гэж шүүмжилсэн.</li> <li>• Иргэний нийгмийн байгууллагын гуравдагч талын хяналт чухал гэж үзсэн (2013 оны Хөвсгөл аймагт хэрэгжсэн жишээг дурдсан).</li> <li>• Амьтан нэвтрэх гарц байгуулах шаардлагатай, учир нь амьтан, малын осол ихэссэн.</li> </ul> <p>Эмэгтэйчүүдийн бизнес ба чадавхийн асуудал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эмэгтэй бизнес эрхлэгчид мэдээлэл, сүлжээ, итгэл дутмаг тул худалдан авалтын үйл явцад оролцоо бага байдаг.</li> <li>• Махны үйлдвэрлэл болон Европын Холбоо, Арабын зах зээлд гарах стандартын мэдлэг дутмаг.</li> <li>• Чадавх бэхжүүлэх сургалт, зорилтот дэмжлэг шаардлагатай.</li> <li>• Жендэрт суурилсан хүчирхийллийн эрсдэл өндөр гэж үзсэн.</li> <li>• КОВИД-19 нь ЖДҮ болон албан бус бизнесүүдэд сөргөөр нөлөөлсөн.</li> <li>• Эмэгтэйчүүдийн бизнесийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх шаардлагатай.</li> </ul>

<p>Төслийн хамрах хүрээний 8 аймгийн төрийн болон орон нутгийн байгууллагууд (аймгийн ЗДТГ, байгаль орчин, тусгай хамгаалалттай газар, газар зохион байгуулалт, соёлын өв, төлөвлөлтийн нэгжүүд; төрийн өмчит авто замын засварын компаниуд)</p>	<p>Төслийн ерөнхий концепц; байгаль орчин, нийгмийн эрсдэл; замын зураг төсөл ба эрэмбэлэлт; орон нутгийн хөгжлийн уялдаа</p> <p>Огноо: 2021 оны 6 сарын 21</p>	<p>Замын зураг төсөл ба эрэмбэлэлт:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Шинэ замын зураг төсөл нь уул уурхайн болон хүнд даацын тээвэрлэлтийг харгалзах ёстой.</li> <li>• Барилгын үе шатанд түр зам барих шаардлагатай бөгөөд тоосжилт ихсэх тул усалгаа хийх хэрэгтэй.</li> <li>• Ил тод, оролцоотой уулзалтуудыг зохион байгуулж буйд талархал илэрхийлсэн.</li> <li>• Орон нутгийн аялал жуулчлал болон хөгжлийн зорилтод нийцүүлэн сумдын сонголт хийх санал гаргасан. (Архангай: Чулуут сум аялал жуулчлал; Эрдэнэмандал сум мах боловсруулах пилот; Увс: Сагил, Түргэнээс бусад сумыг авч үзэх гэх мэт)</li> <li>• Гүүр, ус зайлуулах байгууламжуудыг засварлах шаардлагатай.</li> </ul> <p>Байгаль орчны нөлөөлөл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Амьтны ослын статистик болон экологийн цагдаагийн мэдээллийг шалгах шаардлагатай.</li> <li>• Зарим бүсэд модны хулгай нэмэгдэх эрсдэлтэй.</li> <li>• Зам барилгын материал олборлолт нь бэлчээр ашиглалтын маргаан үүсгэж болзошгүй.</li> </ul> <p>Оролцогч талуудын оролцоо:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Аймгийн байгууллагууд болон замын компаниуд төлөвлөлтөд оролцох сонирхолтой.</li> <li>• КОВИД-ын хязгаарлалт буурсны дараа талбай дээр очиж маршрут сонголт хийхийг зөвлөсөн.</li> </ul>
--	---	--

### ХАВСРАЛТ 3: ЗАГВАРУУД

#### Загвар 1. Зөвлөлдөх уулзалтын тэмдэглэл

Оролцогч тал (бүлэг эсвэл хувь хүн)	Оролцогч тал (бүлэг эсвэл хувь хүн)	Оролцогч тал (бүлэг эсвэл хувь хүн)	Оролцогч тал (бүлэг эсвэл хувь хүн)	Оролцогч тал (бүлэг эсвэл хувь хүн)	Оролцогч тал (бүлэг эсвэл хувь хүн)

#### Загвар 2. Мэдээлэл түгээх, оролцогч талуудын оролцооны бүртгэл

Түгээсэн мэдээлэл	Байршил	Арга хэлбэр	Зорилтот оролцогч талууд	Хариуцсан байгууллагууд



**Загвар 5. ТТАМ-ын талбайн зөвлөлдөх бүртгэлийн маягт**

Багц: \_\_\_\_\_

ТТАМ-ын талбайн байршил: \_\_\_\_\_

Сум / Баг: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

Оролцогчийн нэр	Үүрэг (малчин, газар ашиглагч, албан тушаалтан)	Гол санаа зовоосон асуудал	Зөвшилцсөн бууруулах арга хэмжээ	Гарын үсэг

Нөхөн сэргээлтийн арга хэмжээг тайлбарласан эсэх:

- Тийм
- Үгүй

ГБМ-ыг тайлбарласан эсэх:

- Тийм
- Үгүй

Гүйцэтгэгчийг төлөөлж: \_\_\_\_\_

## Загвар 6. Эмзэг бүлгийн бүлгийн ярилцлагын бүртгэл

Багц: \_\_\_\_\_

Сум / Баг: \_\_\_\_\_

Огноо: \_\_\_\_\_

Хөтлөгч: \_\_\_\_\_

Зорилтот бүлэг:

- Эмэгтэй тэргүүтэй өрх
- Ахмад настан
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
- Бага орлоготой малчин
- Бусад (тодорхойлох)

Хэлэлцсэн сэдвүүд:

- Хандалтын хязгаарлалт
- Малын хөдөлгөөн
- Аюулгүй байдлын эрсдэл
- Гомдол барагдуулах механизмын мэдлэг
- БХМ/БД-ийн мэдлэг, ойлголт

Гол асуудлууд:

---

---

---

Дараагийн арга хэмжээ:

---

---

---

Оролцогчид (Тоо):

Эмэгтэй:

Өндөр настан:

ХБИ:

## **Загвар 7. Гүйцэтгэгчийн ОТХТ-ний хэрэгжилтийн тайлагналын товч агуулга**

Багц:

Улирал:

Бэлтгэсэн:

### 1. Оролцооны үйл ажиллагааны товч

Олон нийтийн уулзалт:

FGD (бүлгийн ярилцлага):

Нэг бүрчилсэн зөвлөлдөх уулзалт:

Байгууллагын уулзалт:

### 2. Оролцооны нэгтгэл

Нийт оролцогч:

Эмэгтэй:

Эмзэг бүлэг:

### 3. Гомдлын нэгтгэл

Нийт хүлээн авсан гомдол:

20 хоногт шийдвэрлэсэн:

Дундаж шийдвэрлэх хугацаа:

Сэтгэл ханамжийн хувь:

### 4. Залруулах арга хэмжээ авсан байдал:

### 5. НТХН-д хүргүүлэх шаардлагатай асуудлууд:

Гүйцэтгэгч: \_\_\_\_\_

Хяналтын инженерийн баталгаажуулалт: \_\_\_\_\_

## **Загвар 8. БХМ/БД асуудлаар мэдлэг олгох сургалтын бүртгэл**

Огноо:

Байршил:

Оролцогчид:

Сургагч багш:

- Хамрагдсан сэдвүүд:
- Ажилтны ёс зүйн дүрэм
- БХМ/БД -ын тодорхойлолт ба жишээ
- Мэдээлэх сувгууд
- Нууцлалын баталгаа

Орон нутгийн лавлагаа үйлчилгээ (эмнэлэг, цагдаа, сэтгэлзүйн үйлчилгээ гэх мэт)